

# САРЫН ТЭМДГИЙН ЭРҮҮЛ АХУЙ СУРГУУЛИЙН ОРЧИНД Өсвөр насны охидын дадал хэвшил болон тэдний боловсрол, эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийг ойлгох нь



СУДАЛГААНЫ ТАЙЛАН

САРЫН ТЭМДГИЙН ЭРҮҮЛ АХУЙ СУРГУУЛИЙН ОРЧИНД:

Өсвөр насны охидын дадал хэвшил болон тэдний боловсрол, эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийг ойлгох нь

## САРЫН ТЭМДГИЙН ЭРҮҮЛ АХУЙ СУРГУУЛИЙН ОРЧИНД:

Өсвөр насны охидын дадал хэвшил болон тэдний боловсрол,  
эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийг ойлгох нь

# СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Энэхүү судалгааг НҮБ-ын Хүүхдийн Сан болон АНУ-ын Эморийн Их сургуулийн мэргэжил, арга зүйн дэмжлэгтэйгээр, Канадын Засгийн газрын санхүүжилтээр “Нийгмийн ажлын хөгжлийн төв” Төрийн бус байгууллага хийсэн болно. Судалгааны тайлангийн агуулга нь судлаачдын багийн дүн шинжилгээ, дүгнэлтэд үндэслэсэн бөгөөд НҮБ-ын Хүүхдийн Сангийн байр суурийг шууд илэрхийлээгүй болно.

НҮБ-ын Хүүхдийн Сан

НҮБ-ын байр, НҮБ-ын гудамж - 14

Улаанбаатар 14201, Монгол Улс

Утас: +976-11 312185, 312217

Цахим шуудан: [ulaanbaatar@unicef.org](mailto:ulaanbaatar@unicef.org)

Вэб хуудас: [www.unicef.mn](http://www.unicef.mn)

Facebook: [www.facebook.com/unicefmongolia](http://www.facebook.com/unicefmongolia)



## АГУУЛГА

<b>ТОВЧИЛСОН ҮГС</b>	<b>II</b>
<b>ТАЛАРХАЛ</b>	<b>1</b>
<b>ХУРААНГУЙ</b>	<b>2</b>
<b>ТАНИЛЦУУЛГА</b>	<b>3</b>
<b>СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ</b>	<b>10</b>
Бэлтгэл ажил	10
Судалгааны загвар, хамрах хүрээ	10
Судалгааны үйл явц	11
<b>ҮР ДҮН</b>	<b>15</b>
<b>Нийгмийн болон орчны хүчин зүйлс</b>	<b>16</b>
Нөхцөл байдлын хүчин зүйл 1. Хөдөө орон нутаг болон хотын захын гэр хороололд ус, усанд орох байгууламжийн хүртээмж	16
Нөхцөл байдлын хүчин зүйл 2. Хот, аймаг болон хөдөөгийн сургуулиудад УАЦЭА-н байгууламж	18
Нөхцөл байдлын хүчин зүйл 3. Эцэг эхийн дэмжлэг	18
Нөхцөл байдлын хүчин зүйл 4. Охидын сарын тэмдэг анх ирэх нас	19
Нөхцөл байдлын хүчин зүйл 5. Өсөн нэмэгдэж буй мэдээлэл болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүртээмж	19
<b>Охидод тулгардаг бэрхшээлтэй асуудлууд</b>	<b>20</b>
<b>Тодорхойлогч болон нөлөөлж буй хүчин зүйлс</b>	<b>22</b>
Тодорхойлогч хүчин зүйл 1: Сургууль болон дотуур байрны УАЦЭА-н байгууламж	22
Тодорхойлогч хүчин зүйл 2: Мэдлэг, мэдээлэл ба боловсрол	29
Тодорхойлогч хүчин зүйл 3. Сарын тэмдэг ирсэн үед яаралтай материалын хүртээмж	34
Тодорхойлогч хүчин зүйл 4: Нийгэм сэтгэл зүйн дэмжлэгт орчин	36
Тодорхойлогч хүчин зүйл 5: Биологийн хүчин зүйлс	38
<b>Боловсрол ба эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, эрсдэл</b>	<b>39</b>
Оролцогчдын дурдсан үр нөлөө	39
Болзошгүй эрсдлүүд, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө	41
<b>ЗӨВЛӨМЖ</b>	<b>44</b>
1. Оролцогчдоос гарсан зөвлөмж	44
2. Судлаачдын зөвлөмж	45
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ</b>	<b>47</b>
<b>ХАВСРАЛТ</b>	<b>48</b>



## ТОВЧИЛСОН ҮГС

АЦБ	Ариун цэврийн байгууламж
АЦХ	Ариун цэврийн хэрэглэл
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ГЯ	Ганцаарчилсан ярилцлага
ГМЯ	Гол мэдээлэгчийн ярилцлага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МХЗ	Мянганы Хөгжлийн Зорилтууд
НҮБХС	НҮБ-ын Хүүхдийн Сан
НҮБХАС	НҮБ-ын Хүн Амын Сан
НҮТС	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
ОУБТС	Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
УАЦЭА	Ус, ариун цэвэр, эрүүл ахуй
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭМСЯ	Эрүүл мэнд, спортын яам



## ТАЛАРХАЛ

Энэхүү судалгаа нь сургуулийн орчин дахь сарын тэмдгийн эрүүл ахуйн нөхцөл байдлын асуудлаар Монгол Улсад хийгдсэн хамгийн анхны чанарын судалгаа бөгөөд тус судалгааг НҮБ-ын Хүүхдийн сангийн захиалгаар, Канадын засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Охидод ээлтэй сургуулийн Ус ариун цэвэр, эрүүл ахуй (УАЦЭХ): Сургуулийн УАЦЭХ хөтөлбөр”-өөр дамжуулан “Сарын тэмдгийн эрүүл ахуйн ухуулга, нөлөөлөл ба чадавхийг бүрдүүлэх” төслийн хүрээнд хийж явуулсан. Судалгааны арга зүй, чанарын дүн шинжилгээ, эцсийн тайлан бичих зэрэгт мэргэжил арга зүйн байнгын дэмжлэг туслалцааг АНУ-ын Эморийн Их сургууль (Бетани Карузо, Анна Еллис, Гаутами Пенакалапати, Глория Склар, Кандис Гирод болон Маттью Фрийман) үзүүлсэн бөгөөд Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам (БСШУЯ) болон Эрүүл мэнд, спортын яам (ЭМСЯ) идэвхтэй оролцож, дэмжлэг үзүүлж ажилласан.

Зохиогчдын зүгээс Нью-Йорк дахь НҮБ-ын Хүүхдийн Сангийн Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн (УАЦЭА) баг, тэр дундаа Мурат Сахин, Лизетт Бургерс, Мариа Кармалита Франсуа, Сью Кавилл болон Юдит Шейдо нарт талархал илэрхийлж байна. Түүнчлэн Колумбын Их сургууль, тэр дундаа Марни Соммер, мөн Нью-Йорк дахь НҮБ-ын Охидын Боловсролын Санаачилгын (UNGEI) Зөвлөх баг, НҮБ-ын Хүүхдийн Сангийн төв оффисийн жендэр, өсвөр үеийн хөгжил, оролцоо болон боловсролын асуудал хариуцсан зөвлөхүүдийн зүгээс үзүүлсэн арга зүйн тусламжид талархаж байгаагаа илэрхийлье.

Түүнчлэн НҮБ-ын Хүүхдийн Сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч Роберто Бэнес, Шадар Суурин төлөөлөгч Жудит Бруно, Ус, орчны эрүүл ахуйн мэргэжилтэн Н.Батнасан, Хөгжлийн мэдээлэл харилцааны мэргэжилтэн М. Одгэрэл, УАЦЭА-н зөвлөх Робин Вард, Б.Уранчимэг нарт чин сэтгэлээсээ баярлалаа.

Монголын Нийгмийн ажлын хөгжлийн төвийн судалгааны багийн ахлагч Ц.Эрдэнэчимэг, судлаач НЭМ-ийн магистр Ж.Наранчимэг (судлаач, тайлангийн редактор), Төрийн захиргааны магистр С.Оюунтөгс, Нийгмийн ажлын магистр Б.Алтанцэцэг, Профессор Т.Амаржаргал, Нийгмийн ажлын бакалавр Ч.Гэрэлмаа, Г.Батсуурь нарт онцгойлон талархаж байна.

Эцэст нь судалгаанд оролцон, энэхүү эмзэг асуудлаар туршлага, санаа бодлоо хуваалцсан бүх сургуулийн удирдлага, сурагчид, багш нар болон гол мэдээлэгч нартаа гүн талархал илэрхийлэхийг хүсч байна.



## ХУРААНГУЙ

Сарын тэмдгийн эрүүл ахуйн нөхцөл байдлын асуудлаар Монгол Улсад хийгдсэн хамгийн анхны чанарын судалгаа болох тус судалгааг Канадын засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр, АНУ-ын Эморийн Их сургуулийн мэргэжил арга зүйн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Хүүхдийн сан болон Нийгмийн ажлын хөгжлийн төв Төрийн бус байгууллага (ТББ) хамтран 2015 оны 2 дугаар сараас 6 дугаар сар хүртэлх хугацаанд хийлээ. Судалгааны зорилго нь сарын тэмдэг ирэх үед охидод тулгардаг хэрэгцээ шаардлага сургууль болон дотуур байрны орчинд хэр сайн хангагдсан байдаг талаарх охидын үзэл бодлыг судлах, охидод ээлтэй сургуулийн орчинг бүрдүүлэх ажилд суурь нотолгоо болохуйц мэдээллийг оролцогч талуудаас цуглуулахад оршиж байв.

Судалгаагаар сарын тэмдэг нь ирсэн охид, ялангуяа сургууль дээрээ байх үедээ эрүүл ахуй, ариун цэвэр болон сэтгэл санааны хувьд маш олон хүндрэлтэй асуудалтай тулгардаг нь харагдсан. Үүнд: бусдаас ичиж зовох, хөвгүүдэд шоолуулахаас айх, тавгүйтэх, хичээлдээ оролцох идэвх сулрах, ангийнхаа бусад хүүхдээс зай барих, хичээлээс анхаарал нь сарних, сарын тэмдгийн үед ариун цэврээ сахих хувийн орон зай бүхий ариун цэврийн байгууламж дутагдах зэрэг олон асуудал байна. Эдгээрийн улмаас охидын хичээл болон сургуулийн үйл ажиллагаанд оролцох идэвх нь илт буурах, цаашилбал хичээл таслах явдал гардаг ба энэ нь тэдний сурлагын амжилтад төдийгүй бие махбод, сэтгэл санааны байдалд таагүй нөлөө үзүүлж байна.

Хөдөө орон нутаг ба хотын захын гэр хороололд усан хангамж, халуун усны газрын хүртээмж тааруу, дотуур байранд эсвэл айлд амьдардаг охидод эцэг, эхийн халамж, анхаарал дутдаг зэрэг нийгэм болон орчны сөрөг хүчин зүйлс нь дээрх бэрхшээлүүд үүсэхэд нөлөөлж байна. Түүнээс гадна гэр бүл болон сургуулийн орчинд охидод үзүүлэх нийгэм-сэтгэлзүйн болон биет дэмжлэгийн чанар, хүртээмж хангалтгүй, ойролцоох дэлгүүрүүд дэх ариун цэврийн хэрэгслийн (АЦХ) үнэ өртөг, олдоцын асуудал, зурагт, интернэтээс авах мэдээллийн хүртээмжийн өсөлт зэрэг бусад хүчин зүйлс ч нөлөөтэй.

Судалгаанаас гарсан дараах гол зөвлөмжүүд сарын тэмдгийн эрүүл ахуйг сайжруулах бодлого, хөтөлбөрийг боловсруулах ажлыг чиглүүлэх зорилготой:

1. Сургууль, дотуур байрны нөхцөлд сарын тэмдгийн эрүүл ахуйг сахихад охидод нэн тэргүүнд шаардлагатай наад захын хэрэгцээ нь усны найдвартай эх үүсвэр, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай байх явдал юм. Иймд Засгийн газраас 2015 онд баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага”-ын хэрэгжилтийг сайжруулах нь чухал байна.
2. Сарын тэмдэг, түүнийг зөв зүйтэй зохицуулах талаарх охид, хөвгүүд, багш нар (ялангуяа эрэгтэй багш нар), эцэг эхчүүдийн мэдлэг, хандлага, дадлыг сайжруулах хөтөлбөр төлөвлөж, боловсруулж, танилцуулах. Үүнд мэдээлэл, сурталчилгааны материал, гарын авлага, онлайн сургалтын материал боловсруулах, сургуулийн эмч нарыг сургах, мөн багш, эмч, дотуур байрны багш нар, үйлчлэгчдийн ажлын байрны тодорхойлолтыг хянах зэрэг ажлыг тусгаж болох юм.
3. Охид хичээлийн цагаар ариун цэврийн хэрэгсэл олж авах боломжийг нэмэгдүүлэх, сургуулийн эмч, багш нар, сургуулийн бусад ажилтнууд ба хөвгүүдээс охидод биет болоод сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх ээлтэй орчинг бүрдүүлэх.





## ТАНИЛЦУУЛГА

### Судалгааны үндэслэл

Сарын тэмдгийн эрүүл ахуйн асуудалд хандуулах анхаарал олон улсын хэмжээнд улам бүр өсөн нэмэгдэж, Ази, Африк, Латин - Америкийн хэд хэдэн улс оронд (Руанда, Боливи, Филиппин, Сиерра Леон) энэ асуудлаар судалгаа хийгдсэн төдийгүй олон улсын хэд хэдэн хурал зохион байгуулагдаад байна. Харин Монгол Улсад сарын тэмдгийн асуудлаар тусгайлсан судалгаа харахан хийгдэж байгаагүй. Иймээс НҮБ-ын Хүүхдийн Сан энэхүү судалгааг Эморийн Их сургуультай хамтран 2015 онд хийхээр шийдсэн юм.

Бусад улс оронд хийсэн судалгааны дүнгээс харахад сургуулийн УАЦЭА-н байгууламж шаардлага хангахгүй байх, сарын тэмдгийн талаарх мэдлэг, ойлголт тааруу байх зэргээс үүдэн охид сарын тэмдгийн үедээ айх, сэтгэл санаа хямрах, ичиж зовох гэх мэт нийтлэг бэрхшээлтэй тулгардаг нь тэдний сурах үйл явцад сөргөөр нөлөөлж, улмаар хичээл таслах, хичээлд оролцох оролцоо нь багасах, анхаарал нь сарних, цаашилбал удаан хугацааны эрүүл мэндийн асуудал ч үүсэх эрсдэлтэй байдаг байна.

Тус судалгааны зорилго нь сарын тэмдэг нь ирэх үед охид сургуулийн орчиндоо ямар хүндрэл бэрхшээлтэй тулгардаг талаар мэдээлэл цуглуулах, эдгээр бэрхшээлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, шийдвэр гаргагчид, сургуулийн удирдлага болон бусад холбогдох талуудад зөвлөмж гаргахад оршиж байсан.

### Монгол Улс ба өнөөгийн хөгжил

Монгол Улс нь Зүүн хойд Азид оршдог далайд гарцгүй улс бөгөөд хойд хэсгээрээ Оросын Холбооны Улс, урд хэсгээрээ Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хиллэдэг (Зураг 1).

Тус улс нь 1,564,900 км<sup>2</sup> газар нутагтай, нийслэлээс гадуурх нэг хавтгай дөрвөлжин километр газарт хоёр хүрэхгүй хүн ногддог, дэлхийн хоёр дахь хамгийн сийрэг хүн амтай улсад тооцогддог. Нийт хүн ам нь гурван сая<sup>1</sup> гаруй, түүний тал нь хот, аймгийн төвд, ялангуяа нийслэл хот Улаанбаатарт төвлөрөн амьдарч байна.

Зураг 1. Монгол Улсын газрын зураг



<sup>1</sup> УХХ, Статистикийн эмхэтгэл 2015 .

Монгол Улс нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөл нь урт бөгөөд дундаж температур нь хасах 15-30°C хүрдэг.

Засгийн газрын тогтолцоо нь төвлөрсөн бус, засаг захиргааны хувьд 21 аймагт, аймаг бүр сум, багт хуваагддаг. Нийт 330 сум, 1,592 багтай. Нийслэл хот Улаанбаатар 9 дүүрэг, 152 хороонд хуваагддаг.<sup>2</sup>

Монголд хотжилт маш хурдацтай явагдаж байна. 2014 оны тооцоогоор хот суурин газрын оршин суугчид нийт хүн амын 66.4 хувийг (Улаанбаатар хотод 45.5 хувь буюу 1.31 сая), нийт өрхийн 65.3 хувийг тус тус эзэлж байна. Хот суурин тийш чиглэсэн дотоодын шилжилт хөдөлгөөн 2000 оноос эхлэн нэмэгдсэн нь зудын гамшгийн уршгаар мал сүргээ алдсан малчид амьжиргааны өөр арга зам хайж суурин газар луу шилжиж байгаатай голчлон холбоотой юм.

Ер нь хүн амын шилжилт нь эдийн засгийн хөгжил, бүсийн тэнцвэргүй байдлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлдэг гэж үздэг. Хэдий тийм ч, Монголд явагдаж буй хотжилт нь Улаанбаатар ба суурин газруудад хүн ам хэт ихсэх, усан хангамж болон бусад үйлчилгээний хүртээмжид хүндрэл үүсгэх зэрэг олог сөрөг үр нөлөө дагуулж байна.<sup>3</sup> Ариун цэвэр, төвлөрсөн ус хангамжтай орчин үеийн дэд бүтцэд холбогдсон хотын төвийн оршин суугчидтай харьцуулахад хот сууринд шилжин ирэгсдийн ихэнх нь үйлчилгээ дутмаг гэр хороололд амьдарч байна.

#### *Зураг 2. Улаанбаатар хотын захын төлөвлөгдөөгүй гэр хороолол*




*Эх үүсвэр: Азийн сан*

<sup>2</sup> УСГ, Статистикийн эмхэтгэл 2014.

<sup>3</sup> Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт: Үндэсний тав дахь илтгэл, 2013.

Нийт хүн амын 36 хувийг 19 хүртэлх насныхан эзэлдэг Монгол Улс нь залуучуудын орон юм.

Зураг 3. Монгол Улсын хүн амын суварга, 2014<sup>4</sup>



Мянганы Хөгжлийн Зорилтуудын (МХЗ) хэрэгжилт: 2013 оны Үндэсний тав дахь илтгэлээс үзэхэд ажил эрхлэлтийн түвшин 2009 онд 88.4 хувьтай байсан бол 2012 онд 91.8 хувь хүртлээ өсчээ. Ажиллах хүчний оролцоог 70 хувьд хүргэх зорилттой бөгөөд 15-24 хүртэлх насныхны дунд ажилгүйдэл 2.5 хувьтай байна.

### Ус, ариун цэвэр ба эрүүл ахуй

Улс орны хөгжлийн урьдчилсан нөхцөл нь ус, ариун, цэвэр эрүүл ахуй гэдгийг улс төрийн хувьд хүлээн зөвшөөрч, олон нийтийн ойлголт өсөн нэмэгдэж байгаа үед Эрүүл ахуй ба усны асуудлыг зохицуулах удирдах хороонд Засгийн газар 2015 оноос орж ажиллаж байна. Хэдий тийм боловч энэ салбарт гарч буй ахиц дэвшил чамлалттай хэвээр байна.

Монгол орны байгаль орчны болон ахуй амьдралын нөхцөл харилцан адилгүйн дээр хүндрэл бэрхшээл ихтэй байдгийн нэг илрэл нь МХЗ-ын УАЦЭА-н шалгуур үзүүлэлт, зорилтуудад хүрэх явц болон түвшин, тэр дундаа ариун цэврийн зорилт, үзүүлэлтүүд усан хангамжийнхаас хоцорч байгаагаар харагдаж байна.

**Монгол Улс жилдээ 35.5 тэрбум төгрөг буюу 26 сая ам.долларыг ариун цэвэр, эрүүл ахуйн муу нөхцлийн улмаас алдаж байгаа нь ойролцоогоор дотоодын нийт бүтээгдэхүүний 0.5 хувьтай тэнцэж байна.**

Эх үүсвэр: Монгол Улс дахь эрүүл ахуйн эдийн засгийн үр нөлөө (2011)

<sup>4</sup> <https://populationpyramid.net/mongolia/2016/>.

Ус, ариун цэврийн үзүүлэлтүүд үндэсний хэмжээнд зогсонги байгаа бөгөөд ундны усны сайжруулсан эх үүсвэрийн хангамж 2010 онд 65.2 хувь байснаа 2013 онд дөнгөж 68.1 хувьд хүрч нэмэгдсэн бол сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмж дээрх хугацаанд зөвхөн 54.3-аас 58.3 хувьд хүрчээ. <sup>5</sup>

ДЭМБ, НҮБХС-ийн Ус ба Ариун цэврийн хяналт шинжилгээний хамтарсан хөтөлбөрөөр ([http://www.wssinfo.org/documents/?tx\\_displaycontroller\[type\]=country\\_files](http://www.wssinfo.org/documents/?tx_displaycontroller[type]=country_files)), ус, ариун цэврийн сайжруулсан байгууламжийн хүртээмжийн чиг хандлага нь 2010-2015 онд Монгол Улсад бага зэрэг өссөн, гэхдээ бараг зогсонги байдалд байна (Ус: 63% - 64%, ариун цэвэр: 57%-60%). Хяналт шинжилгээний хамтарсан хөтөлбөр нь үндэсний хэмжээнд хийгдсэн бүхий л судалгааны үр дүнд суурилж (Хүн ам, орон сууцны тооллого, Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа (ОУБТС) буюу Хүүхэд хөгжил судалгаа, Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Өрхийн түвшний туршилтын судалгаа, Өрхийн орлого, зарлагын судалгаа г.м.) жил бүрийн таамаглалыг тооцоолдог. Хүүхэд, хөгжил судалгаагаар (<http://mics.unicef.org/surveys>) ус, ариун цэврийн сайжруулсан байгууламжийн хангамж 2010 оноос бага зэрэг нэмэгдэж иржээ (Ус: 65% - 68%, Ариун цэвэр: 54%-58%). Гэхдээ улс орны өвөрмөц тодорхойлолтоор ариун цэврийн байгууламжийн хангамж ихээхэн буурсан (83%-аас 27% хүртэл) нь сүүлийн судалгаанд өрхийн энгийн нүхэн жорлонг сайжруулаагүй жорлонд тооцож оруулснаар тайлбарлаж болно.

*Хүснэгт 1. Усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хангамж, хүн амд*

Үзүүлэлт	2005	2010	2013/2014
Баталгаат ундны усаар хангагдсан хүн ам, %	71.6	65.2 (77.9*)	68.1 (84.8*)
Сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хангамж, %	77.2	54.3 (83.1*)	58.3(27.3*)

*Тэмдэглэл: \*-тухайн улсын өвөрмөц тодорхойлолтоор*

УАЦЭА-н үйлчилгээг хүргэхэд Монгол Улсын хувьд нэлээд бэрхшээлтэй юм. Хөрсний цэвдэг, орон нутагт үйлчилгээ үзүүлэх дэд бүтэц дутагдалтай болон бусад хүчин зүйлсийн нөлөөгөөр алслагдсан газар нутагт УАЦЭА-н дэд бүтцийг байгуулах, ажиллуулах, засвар үйлчилгээ хийх нь маш өндөр өртөгтэй. Эдгээр саад тотгорын улмаас хөдөөгийн болон хотын захын гэр хорооллын дийлэнх өрхүүд нүхэн жорлонтой бөгөөд ариун цэврийн байгууламжийн хэрэглээний тэгш бус байдал нь айл өрхийн амьдарч буй байрлалтай ихээхэн хамааралтай байдаг.

Ус, ариун цэврийн сайжруулсан байгууламжийг ашиглах (эсвэл ашиглахгүй байхтай) уялдсан жендэрийн хэм хэмжээ болон үүргийн хувьд их ялгаа харагддаггүй бөгөөд ерөнхийдөө насанд хүрсэн эрчүүд хол зайтай орших усны эх үүсвэрээс өрхийн хэрэглээний усаа зөөх ажлыг хариуцан гүйцэтгэдэг байна. <sup>6</sup>

Дүгнэж хэлэхэд, сайжруулсан усны эх үүсвэр ба ариун цэврийн байгууламжийн хэрэглээний хувьд хөдөөгийн (ялангуяа суурин газраас гаднах өрхүүд) болон ядуу өрхүүдийн нөхцөл байдал илүү тааруу байх хандлагатай байна.

<sup>5</sup> ОУБТС/Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (НҮТС) Монгол Улс, 2013

<sup>6</sup> НҮТС, Монгол Улс, 2013

### Монгол Улсын боловсролын байдал

Монгол Улс нь боловсролын салбартаа онцгой амжилтад хүрсэн. Сургуулиуд нь хүүхдэд илүү ээлтэй болж, насанд хүрэгсдийн бичиг үсэг тайлагдалт болон сургуульд хамрагдалт өндөр түвшинд хүрч чадсан.

Охид боловсролын системд хаягдаагүй, зохих байр сууриа эзэлж байгаа нь тэмдэглүүштэй амжилт юм. Хөвгүүдтэй харьцуулахад охидын сургуульд элсэх болон хамрагдах түвшин илүү өндөр, бас сургууль завсардалт бага (охид 35 хувьтай, хөвгүүд 65 хувьтай) байна. Сурагчдын хүйсийн харьцаа ойролцоогоор тэнцүү боловч ерөнхий боловсролын дунд сургуульд охидын эзлэх хувь өндөр байна.<sup>7</sup>

Тус улс 12 жилийн үнэ төлбөргүй ерөнхий боловсролын системтэй: таван жилийг бага боловсрол, дараагийн дөрвөн жилийг бүрэн бус дунд (зайлшгүй эзэмших есөн жилийн боловсролын мөчлөг) болон дахин гурван жилийг бүрэн дунд боловсрол эзэмшихэд зарцуулдаг. Зургаан наснаас бага ангид элсэн ордог.

Боловсролын систем нь сургуулийн өмнөх (ясли, цэцэрлэг) болон ерөнхий боловсролын сургуулиас (бага, бүрэн бус дунд ба бүрэн дунд) тогтдог. Бага, бүрэн бус дунд болон бүрэн дунд сургуулиуд нь ихэнхдээ нэг дор байдаг. Томоохон дагуул хот болон нийслэл хотын сургуулиуд 12 дугаар анги хүртэлх бүх бүлэгтэй. Бага, ерөнхий боловсролын үйлчилгээг бүх газарт, хөдөөгийн захын сумдад ч авах боломжтой. Нийт сургуулийн 68 хувь нь Улаанбаатар хот ба аймгийн төвүүдэд, 31 хувь нь сумдын төвд, үлдсэн 1 хувь нь багийн төвд байрлаж байна.

Суурин газраас алс хол амьдардаг малчдын хүүхдүүдийг сургуульд суралцах боломжоор хангахад чиглэсэн сургуулийн дотуур байруудыг ажиллуулдаг нь Монгол Улсын бага, дунд боловсролын өвөрмөц онцлог юм. Сургуулийн хичээлийн жил нь (есдүгээр сараас тавдугаар сар хүртэл) дундаж температур нь -30°C хүртэл буудаг хатуу хүйтэн өвлийн сартай гарцаагүй давхацдаг тул сурагчдын хувьд дотуур байрандаа байнга амьдрах нь холоос хичээлдээ өдөр бүр ирж, буцалгүй суралцах хамгийн сайн гарц болдог. Хөдөөгийн сургуулиуд дотуур байртай байх нь түгээмэл зүйл. Харин аймгийн төвийн зарим болон цөөн тооны хотын сургуулиуд дотуур байртай байдаг.

Нийт сургуулийн 60 хувь нь дотуур байртай, үүнд нийт сурагчдын 6.5 хувь нь амьдарч байгаагийн 51.7 хувь нь охидууд байна.

Үүнээс гадна олон хүүхэд сургуультайгаа ойрхон айлд (ихэнх нь хамаатан садныдаа) амьдарч, сургуульдаа явдгийг тэмдэглэх нь зүйтэй.

### Сургуулийн эрүүл мэндийн боловсрол

Монгол Улсын Засгийн газар 2015 оны хичээлийн жилийн эхнээс эрүүл мэндийн бие даасан хичээлийг сургалтын хөтөлбөрөөс хасах шийдвэр гаргасан. Үүний оронд эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг бусад хичээлд интеграцчилан оруулахаар ажиллан, хичээл зааж буй бүх багш нарт эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг хичээлийнхээ агуулгад, ялангуяа биеийн тамир, биологийн хичээлд багтаан тусгах зааварчилгааг өгсөн.

Боловсролын судалгааны хүрээлэн нь ерөнхий боловсролын сургуулийн болон Боловсролын их сургуулийн Багшийн коллежийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрийг дахин хянаж, боловсруулах ажлыг ахалж байна.

<sup>7</sup> ҮСХ, Статистикийн эмхэтгэл, 2014.

Өмнөх эрүүл мэндийн тусдаа хичээлээр олгож байсан сургалтын хөтөлбөрийг 20 гаруй жилийн өмнөөс дунд сургуульд зааж эхэлсэн бөгөөд сургуулийн 5-12-р ангийн бүх сурагчдад эрүүл мэндийн тусдаа хичээл орж амьдрах ур чадварыг суулгах зорилготой байсан юм. Уг сургалтын хөтөлбөр нь нь өсвөр үеийн жирэмслэлт, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-ын тархалт зэрэг өсвөр үеийнхний бэлгийн эрсдэлт зан үйл, эдгээрийн үр дагаврыг бууруулахад голлон анхаарч насанд нь тохирсон, бэлгийн цогц боловсрол ба мэдээллээр хүүхэд залуучуудыг хангаж байв.

Сургуулийн эрүүл мэндийн хичээлийн ирээдүй одоогоор тодорхойгүй байна. Өмнөх сургалтын хөтөлбөрт сарын тэмдгийн талаар бараг тусгагдаагүй байсан тул одоо эхлээгүй байгаа биеийн тамир, биологийн болон эрүүл мэндийн нэгтгэсэн хөтөлбөрт үүнийг оруулах эсэх нь мэдэгдэхгүй байна. Сургуулийн эмч нар сургуулийн орчны цэвэрлэгээ, ариун цэвэр болон эрүүл ахуйг голлон анхаардаг тул яаралтай тохиолдолд охидыг ариун цэврийн хэрэгслээр хангах хангалттай нөөц бололцоо тэдэнд байдаггүй гэжээ.

### Сургуулийн УАЦЭА ба сарын тэмдгийн эрүүл ахуй

Засгийн газраас сургуулийн УАЦЭА-н байдалд тавих анхаарал, хүчин чармайлт ихээхэн нэмэгдэж байгаа ч хүүхдүүд эрүүл мэндийн цогц боловсрол авч чадахгүй байгаагийн зэрэгцээ сургуулийн орчинд хүүхдэд ээлтэй УАЦЭА-н байгууламж хангалтгүй байгаагаас сурагчид, ялангуяа хөдөө сумын сургууль, дотуур байрны сурагчид хүндрэл бэрхшээлтэй нүүр тулсаар байна. Байршил нь сургуулийн УАЦЭА-н байгууламжийн стандартыг тодорхойлогч гол хүчин зүйл бөгөөд энэ нь өрхийн хувьд ч ижил юм. Хэдийгээр сургуулийн УАЦЭА-н байгууламжид хийсэн суурь үнэлгээ мэдээлэл байхгүй, УАЦЭА-ны үзүүлэлтүүд Боловсролын салбарын удирдлага мэдээллийн систем болон үндэсний боловсролын тоон мэдээлэлд одоогоор ороогүй байгаа боловч, НҮБ-ын Хүүхдийн Сангаас 2007 онд хийсэн судалгаагаар нийт сургуулийн 78 хувь нь гаднаа бие засах газартай байжээ. ДЭМБ-ын “Сургуульд суурилсан хүүхдийн эрүүл мэндийн судалгаа” (2010) нь үндэсний хэмжээнд түүвэрлэлт хийсэн бөгөөд “арван сурагчийн нэг нь (9.7 хувь) сургууль дээр жорлон эсвэл гар угаалтуур байдаггүй, 35,4. хувь нь сургууль дээр хангалттай тооны жорлон эсвэл гар угаалтуур байдаггүй ” гэж хариулжээ.

Хэдийгээр батлах суурь тоо баримтгүй ч, НҮБ-ын Хүүхдийн Сангийн 2007 оны судалгаанаас хойш зарим ахиц гарсан гэж үзэж болох боловч ялангуяа Монголын эрс тэс цаг уурын нөхцөлд хөдөөгийн олон сургууль, дотуур байрнууд нүхэн жорлонтой, шаардлага хангахгүй УАЦЭА-н байгууламжтай байсаар байна. Хөдөөгийн сургуулийн болон дотуур байрны сурагчид хүйтэн өвлийн саруудад гадаа байрлах бие засах газрыг ашиглаж байгаа нь бодит бэрхшээл бөгөөд бага насны олон хүүхэд эсвэл хөвгүүд нүхэн жорлонд оролгүй гадна талд нь бие засдаг байна. Ихэнх тохиолдолд нүхэн жорлонгууд гэрэлтүүлэггүй, сургууль, дотуур байрнаас хол зайтай байрладаг. Сургуулийн орчинд ил задгай бие засах нь нэг талаасаа дадал хэвшилтэй, нөгөө талаас орчин нөхцөл муутай, ялангуяа үнэртэй, бохир эсвэл өвлийн цагт хальтиргаа ихсэх зэрэгтэй холбоотой юм. Улаанбаатар хотын гэр хороололд амьдардаг хүүхдүүд гэртээ байхдаа нийтийн эсвэл өрхийн бие засах газраа ашигладаг боловч, харин тэдний сурдаг сургууль нь дотроо татуургатай бие засах газартай байдаг. Хөдөө сумын төвүүдэд заримдаа нийтийн халуун усны ганц газартай, сургууль дээр шүршүүрт орох боломжгүй байдаг.

Сургуулийн орчинд эрүүл байх, эрүүл ахуйн нөхцлийг бүрдүүлэхэд төрийн болон ТББ-ууд үндэсний болон орон нутгийн түвшинд чухал үүрэг гүйцэтгэж байна. Хэдийгээр маш идэвхтэй боловч сургуулийн орчны УАЦЭА-н хөдөлгөөн нь оролцогчдын тоо болон санхүүжилтийн хувьд харьцангуй жижиг салбар юм. Засгийн газрын талаас гол үүрэг хүлээгсдэд БСШУЯ, Барилга,

хот байгуулалтын яам, Стандартчлал, хэмжил зүйн үндэсний төв болон Усны үндэсний хороо орж байна. УАЦЭА-н дэвшлийн төв (үндэсний ТББ), Азийн Хөгжлийн Банк, НҮБ-ын Хүүхдийн Сан, Японы Хүүхдийг Ивээх Сан, Япон улсын Засгийн газар зэрэг үндэсний, олон улсын болон олон талт хамтын ажиллагааны байгууллагууд нь хүүхдийн сурах орчинг сайжруулах, УАЦЭА-тай холбоотой төслүүдийг хэрэгжүүлэх, сургуулийн болон дотуур байрны барилга, сургууль ба цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг барих, шинэчлэхэд хөрөнгө оруулах төдийгүй сургуулийн сургалтын хөтөлбөрт эрүүл ахуйн боловсролыг нэгтгэн тусгах чиглэлээр засгийн газрын хүчин чармайлтыг дэмжсээр ирсэн билээ. Сургуулийн УАЦЭА-н дэд бүтцийн төслүүд нь хот, хөдөөд дотор байрлах угаалгын өрөөг нөхөн сэргээх эсвэл барихад илүүтэй анхаарч ажилладаг.

Засгийн газраас хүүхдийн чанартай боловсрол эзэмших таатай орчинг бүрдүүлэх үүргийнхээ хүрээнд УАЦЭА-н холбогдолтой олон тооны хууль, журмыг баталсан юм.

Хамгийн чухал холбоотой баримт бичиг бол НҮБ-ын Хүүхдийн Сангийн салбар хоорондын зохицуулалт болон ухуулга сурталчилгааны дэмжлэгтэйгээр БСШУЯ, ЭМСЯ болон Сангийн яамнаас (СЯ) хамтран боловсруулж гаргасан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлагууд” юм. Үүнийг 2015 оны зургадугаар сард албан ёсоор баталсан билээ.

Эдгээр асуудлын талаар ярилцлагад оролцсон охидын туршлага, УАЦЭА-н чиглэлээр ажилладаг оролцогч талууд, олон улсын болоод орон нутгийн засгийн газрын төлөөлөл болон ТББ-тай хийсэн зөвлөлдөх уулзалтаас гарсан санал, бодлыг энэхүү норм, шаардлагуудад тусгасан байна.

2015 он нь БСШУЯ-аас дээрх норм, шаардлагуудыг хэрэгжүүлэх үүднээс Сургуулийн УАЦЭА-н үндэсний салбар хоорондын зохицуулалттай хөтөлбөрийн эхлэлийг тавьсан чухал ач холбогдолтой жил байлаа. БСШУЯ стандартыг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж байгаа бөгөөд сургуулийн УАЦЭА-н сүлжээний анхны уулзалт саяхан хийгдлээ. Эхний уулзалтаар норм, шаардлагыг өөрсдөө хянах-шалгах маягыг хэлэлцсэн ба энэ нь сургуулийн УАЦЭА-н үндэсний суурь мэдээллийг бий болгох, жил бүр тогтмол хяналт шинжилгээ хийхэд нааштай үр дүн өгөх болно гэж найдаж байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд хэдийгээр ойрын жилүүдэд эерэг ахиц дэвшлүүд гарсан ч ихэнх тохиолдолд сургууль, дотуур байрны УАЦЭА-н нөхцөл хангалтгүй хэвээр, даацтай өөрчлөлт хийх шаардлага байсаар байна. Сургууль, дотуур байрны хүүхдийн тоо хэт их, эрүүл ахуйн нөхцөл муутай, үндэсний норм, шаардлагад хүрэхэд хэтэрхий хол хэвээр байна. Сургуульд УАЦЭА-н үйлчилгээг үзүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл нь сурагчдын сурсан эрүүл ахуйн зөв дадал хэвшлийг сулруулах хүргэх талтай. БСШУЯ-ны удирдлага дор Сургуулийн УАЦЭА Үндэсний хөтөлбөр хэрэгжиж байгаа нь сарын тэмдгийн эрүүл ахуйг сайжруулж, сурагч охидод өгөөжтэй ажлыг хэрэгжүүлэх таатай боломжийг олгож байгаа юм.



## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

### Бэлтгэл ажил

- Хамтран ажиллаж буй БСШУЯ болон ЭМСЯ-ны холбогдох мэргэжилтнүүд, ажилтнууд оролцсон ажлын хэсэг байгуулагдсан.
- Гол яамд, НҮБ-ын Хүүхдийн Сан, ТББ-ууд зэрэг үндэсний оролцогч талуудын төлөөллүүд Эморийн Их сургуулийн Дэлхийн цэвэр усны төв болон НҮБ-ын Хүүхдийн Сангаас зохион байгуулсан цахим сургалтад хамрагдсан.<sup>8</sup>
- Судалгаа хийх ёс зүйн зөвшөөрлийг Монгол Улсын Их сургуулийн Нийгмийн судалгааны ёс зүйн хорооноос авсан. Ёс зүйн зөвшөөрлийн хувийг, судалгаанд туслалцаа үзүүлэхийг хүссэн албан захианы хамтаар аймаг, дүүргийн боловсролын газрын дарга нарт илгээсэн.
- Сонгон авсан сургуулиудын захирал, удирдлагуудад дээрх албан захиаг судалгааны зорилго, зорилтууд, үйл явц болон тоо мэдээлэл цуглуулах цаг хугацааны талаар тодорхой тайлбарласан судалгааны танилцуулга бүхий хувийг бас илгээсэн.

### Судалгааны загвар, хамрах хүрээ

Энэхүү судалгаанд ганцаарчилсан ярилцлага (ГЯ), фокус бүлгийн ярилцлага (ФБЯ), гол мэдээлэгчийн ярилцлага (ГМЯ), ажиглалт зэрэг чанарын болон тоон судалгааны холимог арга хэрэгслийг ашигласан бөгөөд, үүнээс гадна анхны сарын тэмдэг ирсэн туршлагынх нь талаарх түүхийг охидоор бичүүлсэн.

Тоо баримтын дүн шинжилгээнд Нийгэм-экологийн загварыг ашигласан (Зураг 4) болно.

---

<sup>8</sup> Энэхүү цахим сургалт нь практикийн ажилтнууд болон бодлого боловсруулагчдад чанарын судалгаагаар дамжуулан сургууль дээр охидод сарын тэмдэг ирсэн үеэр тохиолдох бэрхшээлийг судлах, ойлгох ур чадвар олгоход чиглэсэн ба энэхүү судалгааг Монголд хийхэд үнэлж баршгүй хувь нэмэр болсон юм.



Зураг 4. Сарын тэмдгийн эрүүл ахуйн судалгааны үйл ажиллагаа болон сэдвүүдэд ашигласан Нийгэм-Экологийн Загвар<sup>9</sup>

**Нийгмийн хүчин зүйлс: Бодлого, уламжлал, соёл, итгэл үнэмшлүүд**

- Баримтын судалгаа: сургууль/жэндэр/ УАЦЭА-н бодлого, сургалтын хөтөлбөр ба багшийн сургалтын стандартууд; тайлангууд
- ГМЯ: Үндэсний, олон нийтийн түвшний төрийн албан хаагчид: НҮБ-ын Хүүхдийн Сан, ТББ-ын ажилтан
- ФБЯ, ГЯ: охид, хөвгүүд, багш нар болон эхчүүдийн шаардаж буй хэм хэмжээ, итгэл үнэмшил болон мэдлэг

**Хүрээлэн буй орчны хүчин зүйлс: Ус, эрүүл ахуй болон нөөц бололцооны хүртээмжтэй байдал**

- **Сургуулийн орчин, орон нутагт хийсэн ажиглалт:** УАЦЭА-н нөхцлүүд; АЦХ-ийн олдоч ба үнэ
- **Багш нартай хийсэн ГЯ:** УАЦЭА-н нөөц бололцоо ба дэмжих боломж; охидын боловсролд багш нарын үүрэг
- **Охидтой хийсэн ФБЯ:** Сургуулийн орчны талаарх бодол; УАЦЭА-н байгууламжийн хэрэглээ

**Хүмүүс хоорондын хүчин зүйлс: Гэр бүл, багш нар, үе тэнгийнхэнтэй харилцах байдал**

- **Охид, хөвгүүд болон эхчүүдтэй хийсэн ФБЯ:** анхны сарын тэмдэг ирсний дараа жэндэрийн үүрэгт гарсан өөрчлөлтийн талаарх бодол; гэр бүл, үе тэнгийнхэн болон багш нарын хандах харилцаа; мэдээлэл, зааж сургах болон хэрэгслийн талаарх дэмжлэгийн хүртээмж
- **Багш нартай хийсэн ГЯ:** Охидод дэмжлэг үзүүлэхэд багш нарын үүрэг; бусадтай харилцахад охидод илэрдэг өөрчлөлтүүд

**Хувь хүний хүчин зүйлс: Мэдлэг, ур чадвар, итгэл үнэмшил**

- **Охидтой хийсэн ФБЯ болон ГЯ:** Сарын тэмдгийн биологийн онцлогийн талаарх мэдлэг, сарын тэмдгийн эрүүл ахуйн арчилгааны туршлага; дасан зохицох механизм ба дадал хэвшлээ зохицуулах; хэрэгцээ; сарын тэмдгийн талаарх хандлага, итгэл үнэмшил; өөрөө эрүүл ахуйг зохицуулахын үр ашиг

**Биологийн хүчин зүйлс: Нас, сарын тэмдгийн хэмжээ, мөчлөг**

- **Охидтой хийсэн ГЯ:** Өвдөлтийн зэрэг, үүнд толгой өвдөх, хэвлийгээр базлах ороод, зан аашид нөлөөлөх, сургууль дээрх туршлага; гарах цусны хэмжээ болон сургуулийн орчинд зохицуулах чадвар; анхаарлаа төвлөрүүлэх чадвар, ядрах

## Судалгааны үйл явц

### Танхимын сургалт

Эморийн Их сургууль болон НҮБ-ын Хүүхдийн Сангаас<sup>10</sup> боловсруулсан ФБЯ, ГЯ, ГМЯ, мөн ажиглалт хийх удирдамжийг монгол хэл рүү орчуулж, хоёр сургууль дээр туршилт хийж, дахин засварласан. Судлаачдын зүгээс гэртээ амьдардаг сургуулийн охидтой харьцуулалт хийхийн тулд дотуур байрны охидод зориулсан удирдамж боловсруулахыг зөвлөсөн.

Эморийн Их сургуулийн судалгааны менежер нь бүх судлаачдад гурван долоо хоногийн сургалт явуулсан. Эхний хоёр долоо хоногийн сургалтын үеэр судалгааны хэрэгслүүд, тэдгээрийг хэрхэн нөхцөл байдалд тохируулах, мөн тоон мэдээлэл цуглуулах талаар заасан. Үүнд УАЦЭА, сарын тэмдэг, судалгааны ёс зүй, тоо баримт цуглуулах чанарын аргачлал, арга зүй болон судалгааны бэлтгэл, зохион байгуулалт зэрэг сэдвийг хамарсан.<sup>11</sup> Хоёр дахь сургалт тоо баримтад дүн шинжилгээ хийх болон дүн шинжилгээ хийх аргачлалын асуудалд төвлөрсөн.

### Тоо баримт цуглуулах

Тоо баримтыг 2015 оны 5-р сард цуглуулж дууссан. Сургуулиудын байршил хоорондоо зайтай байсан тул судлаачдын гурван дагуул баг байгуулж тоо баримтыг нэгэн зэрэг цуглуулсан. Эхний байршил дээр бүх багаар хамтдаа ажиллаж, дараа нь гурван байршилд тус тусдаа ажилласан. Дагуул баг бүр Чиглүүлэгч - судлаач, тэмдэглэл хөтлөгч болон зохион байгуулалтын ажлыг голлон хариуцсан орон нутгийн туслах судлаачаас бүрдсэн ба тоо баримт цуглуулах ажлыг хийж гүйцэтгэв.

Сургуулийн захирлуудаас тухайн сургуулийн сурагчид, ажилтнуудын дунд судалгаа хийх зөвшөөрлийг бичгээр авсны дараа тоо баримт, мэдээлэл цуглуулах ажлыг эхлүүлсэн. Аливаа ярилцлага эсвэл хэлэлцүүлгийг хийхийн өмнө оролцогч тус бүрээс бичгээр зөвшөөрөл авч уг хүний сайн дурын оролцоо болон нууцыг хамгаалах нөхцлийг хангасан. Сургуулийн зүгээс эцэг, эхчүүдэд мэдэгдэн, тэднийг төлөөлж захирал, багш нар зөвшөөрөл өгсөн.

<sup>9</sup>“Сургуулийн УАЦЭА: Кочабамбагийн хөдөө нутагт охидын боловсролыг бэхжүүлэх нь”, Боливи улс, Сургуулийн орчин дахь Сарын тэмдгийн эрүүл ахуйн үнэлгээ

<sup>10</sup> “Сургуулийн УАЦЭА охидын боловсролыг дэмжинэ: Сургууль дээр сарын тэмдгийн эрүүл ахуйг сахиулах зааварчилгаа”

<sup>11</sup> Онлайн сургалтын модуль 1-ээс 8-ыг НҮБХС ба Эморийн Их Сургууль явуулсан сарын тэмдгийн талаар “Охидод зориулсан УАЦЭА”

### Сургууль сонголт

Нийгмийн ажлын хөгжлийн төвийн судалгааны баг нь НҮБ-ын Хүүхдийн Сан болон Эморийн Их сургуультай зөвлөн нийт 11 сургуулийг, үүнд баруун, Хангай, төв ба зүүн бүсийн төлөөлөл болгон 4 аймгийн төвийн болон 4 сумын төвийн сургуулийг сонгосон. Мөн Улаанбаатар хотын төвийн нэг болон захын дүүргийн хоёр сургуулийг тус тус сонгосон.

Дээрх сонголтын зорилго нь газар зүйн байршил буюу хүрээлэн буй орчин, УАЦЭА-н байгууламжийн дэд бүтцийн хөгжил, охидын амьдралын хэв маяг ялгаатай байгаа нөхцөлд сарын тэмдгийн талаарх охидын туршлага болон тулгарч буй бэрхшээл, хэрэгцээний ижил төстэй бөгөөд ялгаатай зүйлийг тодорхойлоход оршиж байв. Дотуур байртай сургуулийг зориудаар сонгон энэхүү дэд бүлгийн өвөрмөц талыг олж илрүүлэхийг зорьсон.

### Хүснэгт 2. Сургуулийн түүвэрлэлт

Бүс/аймаг эсвэл УБ хотын дүүрэг	Улаанбаатар хот эсвэл аймаг/сум ба сургуулийн код		Дотуур байртай сургууль
	Хот	Хотын зах	
УБ: Чингэлтэй	1		Үгүй
УБ: Сонгинохайрхан		2	Үгүй
УБ: Налайх		3	Тийм
	Аймгийн төв	Сумын төв	
Төвийн: Дундговь	4	5	Тийм
Зүүн: Дорнод	6	7	Тийм
Баруун: Ховд	8	9	Тийм
Хангай: Хөвсгөл	10	11	Тийм

### Зураг 5. Сонгон авсан сургуулиудын байршил



*Оролцогчдын сонголт*

Багш нарт судалгааны талаар урьдчилан мэдээлэл өгсөн ба, судалгааны зорилтуудын дагуу 12-13 насны болон судалгааны үед сарын тэмдэг нь ирээд хэдэн жил болж байгаа 14 ба түүнээс дээш насны охидын хоёр бүлгийг сонгосон. Хөвгүүдийн бүлэгт 14-16 настай, эрүүл мэндийн хичээлд орж байсан гэсэн шалгуураар оролцогчдоо сонгосон. Сурагчдаас энэхүү судалгаанд оролцох хүсэлтэй эсэхийг нь асуугаад, судалгаанд оролцохыг зөвшөөрсөн хөвгүүдийг хамруулсан болно.

Эцэг, эхчүүдийг хэд хэдэн бүлэгт хувааж, тэдний санаа, бодлын талаар судлаачид сонсож ярилцсан.

*Оролцогчид ба үйл ажиллагаа*

Судалгаанд сургуульд суралцаж буй өсвөр насны охид, хөвгүүд; дотуур байранд амьдарч буй охид, сургуулийн захиргааны ажилтнууд, багш нар, өсвөр насны охидын эцэг эхчүүд, сургууль, дотуур байрны ажилтнууд, үйлчлэгч зэрэг нийт 300 хүн оролцсон. Түүнчлэн 11 сургуулийн УАЦЭА-н байгууламжид ажиглалт хийсэн.

*Хүснэгт 3. Судалгааны үйл ажиллагааны нэгтгэл*

Хэрэгсэл	Оролцогчид/байршил	Хэлэлцүүлэг, ярилцлагын тоо	Оролцогчдын тоо
ФБЯ	12–13 насны охид (сургууль ба дотуур байр)	11	81
	14–16 насны охид (сургууль ба дотуур байр)	11	81
	14–16 насны хөвгүүд	6	47
	Өсвөр насны охидын ээж нар	3	16
	Дунд, ахлах ангийн багш нар	3	14
ГЯ	12–13 насны сургуулийн охид	11	11
	14–16 насны сургуулийн охид	11	11
ГМЯ	Эрүүл мэндийн хичээлийн багш нар	11	11
	Сургуулийн удирдах ажилтнууд	11	11
Богино ярилцлага	Үйлчлэгч нар	7	7
	Нийт	85	300
Түүх бичилт			
Охидын түүх	Зүүн ба баруун бүсийн аймгуудын төвийн болон сумын сургуулийн охидын түүх	10	10

*Хүснэгт 4. УАЦЭА-н байгууламжийн байдалд хийсэн ажиглалт*

	УАЦЭА-ийн байгууламж	Тоо
11 сургуулийн ажиглалтын дүн	Гар угаалтуур	129
	Дотор жорлон	124
	Гадаах жорлон	64
7 дотуур байрны ажиглалтын дүн	Гар угаалтуур	40
	Дотор жорлон	23
	Гадаах жорлон	10

### Ганцаарчилсан ярилцлага

Ганцаарчилсан ярилцлага (ГЯ) нь сарын тэмдгийн талаарх охидын өөрийн туршлага, ялангуяа энэ талаар юу мэддэг, хаанаас мэдээллээ авсан, хэнд илүү итгэдэг талаар ойлгож мэдэхэд чиглэсэн. Мөн хамгийн анхны туршлагаа эргэн санаж, ярихыг тэднээс хүссэн.

### Зураг 6. Охидын ФБЯ



Эх үүсвэр: НАХТ

### Фокус бүлгийн ярилцлага (ФБЯ)

12-13 насны болон 14 ба түүнээс дээш насны охид, 14-16 насны хөвгүүд болон ээж нарын дунд ФБЯ-ыг тус тусад нь зохион байгуулсан. Бүлэг бүр найм хүртэлх тооны оролцогчтой байв.

Охидын дунд хийсэн ФБЯ-аар сургуулийн орчинд сарын тэмдгийн үед тэдэнд тохиолддог нийтлэг асуудлууд, зан үйл, тэдний дасан зохицох механизм, сарын тэмдгийн талаар ойлгох түвшин болон тусламж дэмжлэг авах бололцоог илрүүлэх зорилготой байсан.

Чиглүүлэгч ярилцлагыг удирдан, тэмдэглэл хөтлөгч нь хэлэлцүүлгийг тэмдэглэх, дуу хураагуурт бичих үүрэгтэй ажилласан.

Охидын ФБЯ-д бүлгийн ярилцлага, зураглал хийх, дүрд тоглох зэрэг хэд хэдэн арга зүй ашигласан. Охидоос ердийн нэг охиныг төсөөлөн, түүнд тохиолдож болох туршлагыг зургаар илэрхийлэхийг хүссэн. Ингэснээр сургуулийн орчинд охидууд сарын тэмдэгтэй холбоотой асуудлаа хэрхэн шийдэж зохицуулдаг, хэрхэн дасан зохицдог, шийдвэрлэх шаардлагатай ямар бэрхшээл, асуудлууд байгаа талаар судлаачид илүү гүнзгий ойлгох боломж бүрдсэн. Ээж нар болон хөвгүүдтэй хийсэн ФБЯ-ыг дээрхтэй ижил сэдвүүдэд чиглүүлж, охидод тулгарч буй бэрхшээл, туршлагыг өөр өнцгөөс харах боломж судлаачдад олгосон юм. ФБЯ-ын дараа хоёр хүнтэй баг, ярилцлагын тэмдэглэлээс гол зүйлс, үйл явцын талаар ярилцан, ярилцлагыг кодлох мөн бичлэгийг шалгах ажлыг гүйцэтгэж байсан болно.

### Охидын түүх

Өөр өөр газарт байдаг сургуулийн<sup>12</sup> охидоос (хот, хөдөө, хотын захын) сарын тэмдгийн талаарх өөрийн туршлагаа товчхон бичиж хаяггүй дугтуйд хийж өгөхийг хүссэн. Энэ дасгал нь охидын сурлагын амжилт эсвэл тэдний амьдралын бусад хэсэгт нөлөөлж магадгүй бэрхшээлүүд, үр нөлөөг сайтар ойлгож авахад чиглэсэн.

### Гол мэдээлэгчийн ярилцлага (ГМЯ)

Сургуулийн ажилтантай хийх ярилцлагын зорилго нь эрүүл ахуй, ариун цэврийн байдлыг судлах, сарын тэмдгийн эрүүл ахуйн талаар сурагчдад юу заадаг, сургуулийн орчинд сарын тэмдэгтэй холбоотойгоор тохиолддог бэрхшээлүүд, төсөв болон хангамжтай холбоотой асуултын талаар ярилцахад оршиж байв. Ярилцлагын агуулгыг НҮБ-ын Хүүхдийн Сангийн сургуулийн орчинд УАЦЭА-н байдлыг хянах үнэлгээний багцийн агуулгын дагуу боловсруулсан болно.<sup>12</sup>

<sup>12</sup> НҮБ-ын Хүүхдийн Сан, "Сургуулийн орчинд УАЦЭА-н байдлыг хянах үнэлгээний багц" 2011 оны 4-р сар, Нью-Йорк.

*Сургууль, дотуур байрны ажиглалт*

Сурагчид, тэр дундаа хичээлийн бусад цагаар сургуулийн орчинд амьдардаг буюу дотуур байранд амьдардаг хүүхдүүдэд тулгарч бус бэрхшээлүүдийг сайн ойлгох үүднээс сонгон авсан бүх сургууль, дотуур байрны УАЦЭА-н байгууламжид ажиглалт хийсэн.

НҮБ-ын Хүүхдийн Сангийн сургуулийн орчинд УАЦЭА-н байдлыг хянах багцад орсон хэрэгсэл, шалгах хуудсыг судалгааны зорилгод нийцүүлэн өөрчилж ашигласан болно.

*Бичлэг болон транскрипт бичих*

Оролцогчдоос урьдчилан зөвшөөрөл авсны дараа бүх ярилцлага, хэлэлцүүлгийг дуу хураагуурт хурааж авсан ба үүний дараа судлаачид бичлэг тус бүрийг сонсож, ярилцлага бүрийг үг бүрчлэн цаасан дээр буулгасан.

*Тоо баримтын дүн шинжилгээ*

Нийгмийн ажлын хөгжлийн төвийн судалгааны баг нь Эморийн Их сургуулиас хийсэн чанарын судалгааны дүн шинжилгээ хийх аргачлалын дагуу монгол хэл дээр дүн шинжилгээг хийж дуусгасан. Ярилцлага болон хэлэлцүүлгийн транскриптууд бэлэн болсны дараа, судлаачид кодын дэвтэр боловсруулсан. Судлаачид транскрипт бүрийг бичлэгтэй харьцуулан цэвэрлэж, оролцогчдын нууцлалыг хадгалах үүднээс нэрсийг өөрчилсөн.

Нийгэм-экологийн загвар ашиглан гол кодуудыг тодорхойлж, дүн шинжилгээ хийх явцад дэд-кодуудыг тодорхойлсон. Урьдчилан тодорхойлсон кодуудад амьдралын өөрчлөлт; мэдлэг ба дадал; дэмжлэг; орчин нөхцөл; УАЦЭА-н байгууламж, үйлчилгээ; сургуулийн системийн дэмжлэг; хүндрэл бэрхшээл; ариун цэврийн хэрэгсэл; гэр, сургууль, дотуур байр; үр нөлөө; эрсдэл болон зөвлөмж зэргийг багтаасан.

Нэг транскриптийг кодлоход хэд хэдэн судлаач оролцон судалгааны дүн шинжилгээний системт алдаанаас сэргийлж судалгааны үр дүнгийн чанар ба судалгааны найдвартай байдлыг баталгаажуулсан болно.


Ажиглалтаас гарсан тоон мэдээллийг хүснэгтэд нэгтгэн; судлаачийн ажиглалт хийсэн тэмдэглэлийг баримт мэдээллийн дүн шинжилгээнд тусган агуулгыг илүү өргөн хүрээгээр харуулахыг зорьсон

**ҮР ДҮН**

Энэ хэсэгт судалгаа хийсэн газрын нийгмийн болон хүрээлэн орчин; сургууль дээр охидод тулгарч буй хүндрэл бэрхшээлийн байдалд дүн шинжилгээ хийсэн. Дараа нь эдгээр бэрхшээлийг тодорхойлогч хүчин зүйлс, үр нөлөө болон болзошгүй эрсдэлийг Нийгэм-экологийн загварын хүрээнд тодорхойлсон (өмнө дурьдсан).

Хүснэгт 5: Судалгааны үр дүнгийн схем

- Агуулга:
- Хөдөө орон нутаг болон хотын захын гэр хороололд усан хангамж, усанд орох байгууламжийн хүртээмж муу
  - Хот, аймаг болон сумын сургуулиуд УАЦЭА-н байгууламж муутай
  - Эцэг, эхийн дэмжлэг
  - Охидын анхны сарын тэмдгийн нас
  - Өсөн нэмэгдэж буй мэдээлэл, хэвлэл мэдээллийн хүртээмж



## Нийгмийн болон орчны хүчин зүйлс

Сарын тэмдэг холбоотой охидын туршлага, тэдэнд тулгардаг хүндрэл бэрхшээлийг авч үзэхдээ нийгмийн болон орчны нөлөөллийг харгалзан судалж үзсэн. Тухайлбал амьдарч буй бодит орчин, нийгэм-сэтгэл зүйн орчин, өсөж торнисон соёл уламжлал зэрэг охидын бие махбод, сэтгэл санаа, зан үйлийн төлөвшилд нөлөөлсөөр ирсэн, нөлөөлж буй ирээдүйд нөлөөлөх хүчин зүйлсийг авч үзсэн болно.

Дараах таван гол нөхцөл байдлын хүчин зүйлсийг тодорхойлсон. Үүнд:

- Хөдөө болон хотын захын гэр хорооллуудад усан хангамж, усанд орох байгууламжийн хүртээмж муу
- Хот, аймаг болон хөдөөгийн сургуулиудийн д УАЦЭА-н байгууламж тааруу
- Эцэг эх, гэр бүлийн зүгээс охидод үзүүлэх дэмжлэг
- Охидын анхны сарын тэмдгийн нас
- Өсөн нэмэгдэж буй мэдээлэл, хэвлэл мэдээллийн хүртээмж

### Нөхцөл байдлын хүчин зүйл 1. Хөдөө болон хотын захын гэр хорооллуудад усан хангамж, усанд орох байгууламжийн хүртээмж муу

Хотын захын гэр хороолол, хөдөө орон нутаг, ялангуяа хөдөөгийн сумдад УАЦЭА-н байгууламжийн хүртээмж тааруу байдаг нь усны нөөц хомс, мөн өргөн уудам газар нутагт дэд бүтэц хэтэрхий өндөр өртөгтэй тусдаг зэргээс үүдэлтэй юм. Айл өрхүүд ус дамжуулах төвлөрсөн

системтэй холбогдоогүй бөгөөд ихэнх хөдөөгийн сумд дөнгөж нэгээс хоёр нийтийн халуун усны газартай. Хэрэв ямар нэгэн шалтгааны улмаас халуун ус хаагдвал, нутгийн хүмүүс гэртээ түмпэнд усанд орохоос өөр аргагүйд байдалд хүрдэг бөгөөд ийм байгууламж ч ерөнхийдөө хомс юм. Хөдөөгийн айлуудад усанд орох тусгай өрөө байхгүй тул сарын тэмдэг ирсэн үед биеэ эсвэл хувцсаа угаахад охидод бэрхшээлтэй байдаг.

***“Манай сумын хэмжээнд ганцхан нийтийн халуун усны газар бий. Үргэлж урт оочертой байдаг болохоор бид нар (охидууд) үргэлж тийшээ явах боломжгүй байдаг” (С9\_ОГЯ\_2)***

Алслагдсан газарт амьдардаг малчид өвлийн цагт худаг, булаг эсвэл голоос ус зөөх, зарим айлууд голын цас, мөс хайлуулж хоол, ундандаа хэрэглэдэг. Харин Улаанбаатар хотын гэр хорооллын айлууд ус түгээх газраас усаа авдаг (Зураг 7 харах).

*Зураг 7. Улаанбаатар хотын захын хорооллын ус түгээх цэг*



*Зураг 8. Хөдөөгийн хөвгүүд усаа зөөж байгаа нь*



*Эх үүсвэр: Б. Мөнгөнхишиг, НҮБ-ын Хүүхдийн Сан*

2013 онд хийгдсэн Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанаас (ҮСХ, НҮБ-ын Хүн Амын Сан, НҮБ-ын Хүүхдийн Сан, 2014) үзэхэд насанд хүрсэн эрэгтэйчүүд (62 хувь) болон 15 хүртэлх насны хөвгүүд (7.3 хувь) ихэнхдээ гэрийнхээ усыг зөөдөг байна. Энэ нь охид, эмэгтэйчүүдийг энэхүү ачаалал, үүнд зориулах цагаас чөлөөлөх боловч гэр бүлийнхээ бусад гишүүдээс илүү ус хэрэглэх үед бэрхшээл үүсэж болох юм.

## Нөхцөл байдлын хүчин зүйл 2. Хот, аймаг болон сумын сургуулиудад

### УАЦЭА-н байгууламж тааруу

Хот суурингийн ихэнх сургуулиуд усан татуургатай жорлонтой боловч хэтэрхий олон хүүхэдтэй байдгаас хүрэлцээ хязгаарлагдмал байдаг. Зарим сургуульд хоёр хүүхдийн зориулалтай нэг ширээнд гурван хүүхэд суудаг байхад зарим сургуулиуд гурван ээлжээр хичээллэх нь бий. Жишээ нь, эхний ээлжинд бага анги өглөөний 8-11 цаг хүртэл, дараагийн ээлж (жишээ нь, дунд анги) 11-16 цаг хүртэл, гуравдугаар ээлж буюу ахлах ангийнхан 16-20 цаг хүртэл хичээллэдэг. Хичээлийн өдөр нь бүлэг бүрийн ангийн тооноос хамаардаг бөгөөд голдуу нэг анги дөрвөөс таван хичээлтэй, нэг хичээл нь 45 минут үргэлжилдэг.

Судлаачдын ажигласнаар 2,000-аас дээш сурагчтай хотын хоёр сургууль гурван ээлжээр хичээллэж байсан ба харин ийм системээр хичээллэдэг аймгийн төвийн эсвэл сумын сургуулиуд тааралдаагүй байна.

Аймгийн төвийн сургуулиудад усан татуургатай дотор жорлон болон гадаа нүхэн жорлонгийн аль аль нь байдаг. Дотор жорлонгийн байдал нь Улаанбаатар хотын эсвэл захын сургуулийнхтай ижилхэн, гэхдээ гадаа байрлаж байгаа нь хөдөөгийн сургуулийнхтай ижил нөхцөлтэй байна.

Ихэнх сумын сургууль эрүүл ахуйн шаардлага хангаагүй, хаалгагүй (эвдэрхий эсвэл огт хаалгагүй) гадаа нүхэн жорлонтой тул хүүхэд ганцаараа тухтай бие засах боломжгүй. Мөн голдуу түгжээ, гэрэл, хогийн сав байхгүй зэргээс хүүхдүүд тийм жорлонг ашиглах дургүй байдаг байна.

Охид болон судалгааны бусад оролцогчдын хэлснээр хот, хөдөөгийн сургуулийн бие засах газарт ариун цэврийн цаас ихэнхдээ байдаггүй. Хичээлийн жилийн эхэнд сурагчид ариун цэврийн цаас ангидаа авчирч хадгалдаг бөгөөд бие засахдаа авч гарч хэрэглэдэг байна. Ихэнх тохиолдолд ариун цэврийн цаасаа ангиасаа авч хэрэглэдэг гэж хүүхдүүд хэлж байсан ч иймэрхүү зохицуулалт тэр бүр үр дүнтэй гэж үзэхэд хүндрэлтэй юм.

## Нөхцөл байдлын хүчин зүйл 3. Эцэг эхийн дэмжлэг

Монголчууд охин хүүхдээ боловсролтой болгохыг эрхэмлэдэг уламжлалтай. Ерөнхийдөө, ихэнх эцэг эхчүүд хөвгүүдээсээ илүү охин хүүхдээ боловсролтой болгоход ач холбогдол өгдөг нь охидын ярианаас харагдаж байв. Тэд ээж, эгч, аав болон эмээ нараасаа дэмжлэг сайн авдгаа илэрхийлж байлаа. Ялангуяа, малчин айл өрхийн эцэг эхчүүд нь мал аж ахуйдаа хөвгүүдээрээ илүү туслуулдаг тул тэдний сургууль завсардалтын түвшин охидтой харьцуулахад өндөр байдаг байна.

*"Манай хөдөө охин хүүхэддээ илүү хайртай байдаг... Ер нь л охин хүүхэддээ л илүү анхаардаг шүү дээ." (ХөдөөС9\_ОхидФБХ\_1)*

Гэсэн хэдий ч, гэр бүлийнхэнтэйгээ хамт амьдардаггүй эсвэл дээрээ эгчгүй охидын хувьд сарын тэмдгийн эрүүл ахуйгаа зохицуулахад дэмжлэг бага байдаг гэжээ. Хөдөөгийн охид хичээлийн жилийн туршид дотуур байранд амьдардаг ба хэрэв дотуур байрны орон тоо дууссан бол айлд амьдрахад хүрдэг.



Ийнхүү эцэг, эхээсээ хол, сургуулийн дотуур байранд хичээлийн жилийн турш амьдарч байгаа охидод онцгой анхаарал, халамж шаардлагатай байж магадгүй, юутай ч АЦХ эсвэл бэлэн мөнгө, зөвлөгөө болон сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх хэн нэгэн ойр байх хэрэгтэй юм.

Өөр өөр байршилд хийсэн ФБЯ-д оролцсон охидууд, дотуур байрны охидод мэдээлэл, дэмжлэг хэрэгтэй үед дотуур байрны багш нар болон насаар эгч охидод хандаж болно гэж хэлсэн байхад айлд байгаа охидод ийм сонголт байдаггүй байна. Гэвч энэ асуудал нь уг судалгааны загварт төдийлөн хангалттай тусгагдаагүй бөгөөд цаашид нарийвчлан судлах ёстой зүйл юм. (Хавсралт 1: дотуур байрны хүүхдүүдийн мэдээлэл)

#### Нөхцөл байдлын хүчин зүйл 4. Охидын анхны сарын тэмдгийн нас

13 хүртэлх насны охид нь сарын тэмдэг анх ирэхийн өмнө ба ирсэн үед мэдээлэл, дэмжлэг хангалтгүй байдгаас туршлага, мэдлэг багатай байх нь нийтлэг. Иймээс тэд насаар эгч охидоос илүү бэрхшээлтэй тулгардаг. Эцэг эхчүүд, ялангуяа ээж нар хэтэрхий эрт гэж үзээд урьдчилан тайлбарлаж өгөөгүй тохиолдол олонтаа ба эсвэл өгсөн мэдээлэл нь тодорхой бус, бүрхэг байдаг байна. Иймээс, бага насны охид нь сарын тэмдэг ирж эхлэх үед айж, цочролд ордог ба тэрчлэн энэхүү эмзэг асуудлын талаар бусдад хандаж тусламж гуйхаасаа ихээхэн айж, ичиж зовдог байна.

#### Нөхцөл байдлын хүчин зүйл 5. Өсөн нэмэгдэж буй мэдээлэл болон хэвлэл мэдээллийн хүртээмж

Өнөөдөр хот хөдөөгийн бүх сум, дүүргүүд интернэт болон цахилгаанд холбогдсон байна. Хөдөөгийн хүүхдүүдийн мэдээлэл олж авдаг үндсэн хэрэгсэл нь телевизор бөгөөд тэд телевизээр голдуу кино үздэг. Харин хүүхдэд зориулсан эрүүл мэндийн хөтөлбөр цөөн байдаг. Харин хотын хүүхдүүд интернэтийг мэдээллийн бусад хэрэгслээс илүү ашигладаг бөгөөд засгийн газрын тайланд дурьдсанаар,<sup>13</sup> нийт интернэт хэрэглэгчдийн 84 хувь нь нийслэл хотод байдаг байна.

*“Сургуулийн хэмжээнд ухаалаг утасгүй хүүхэд бараг байхгүй, цаг үргэлж интернэтэд холбогдон хэрэглэж байдаг. Үүгээр биднээс түрүүлээд төрөл бүрийн мэдээлэл авах боломжтой, бас биднээс илүү хурдтайгаар шинэ зүйлсийг сурч байдаг.” (С7\_БагшФБЯ)*

2016 он хүртэл Монгол Улсын хүн амын тал хувийг эзэлж буй хөдөө орон нутгийнхан интернэтэд холбуулахад хотынхонтой харьцуулахад 4-5 дахин илүү мөнгө төлдөг байв. Жишээ нь: Улаанбаатар хотын иргэд 1МВ хэмжээтэй мэдээлэлд 13,000 төгрөг төлж байхад орон нутгийн иргэд 55,000 төгрөг төлж байжээ. Засгийн газраас энэхүү тэгш бус байдлыг хөдөө орон нутагт интернэтийн хүртээмжийг сайжруулах бодлогоор шийдэж байна. Охидын бодлоор интернэтэд хаа сайгүй холбогдох боломжтой, энэ нь мэдээллийн чухал эх үүсвэр бөгөөд, сарын тэмдгийн талаарх мэдээллийг онлайн аргаар авах боломжтой байвал сайн байна гэж тэд хэлсэн юм. Энэ нь мэдээллийг тэгш тарааж бас мэдлэгээ солилцох үр дүнтэй арга зам байж болох талтай.

<sup>13</sup> Интернэтийн үйлчилгээг улсын хэмжээнд ижил үнэ, тарифаар хүргэхийг “Шийдлийн цаг”-аар үүрэг болголоо. at: <http://zasag.mn/news/view/12341>.



## Охидод тулгардаг бэрхшээлтэй асуудлууд

Охидтой хийсэн хэлэлцүүлэг, ярилцлагаар сарын тэмдэгтэй холбоотойгоор тэдэнд учирдаг бэрхшээлтэй асуудлуудыг тодорхойлсон. Түүнээс гадна охид сарын тэмдэг ирдэг болсноос хойш бие болон сэтгэл санааны хувьд юу мэдэрдэг болсон, тэдний хандлага, дадал хэвшил хэрхэн өөрчлөгдсөн түүхээ судлаачидтай хуваалцсан билээ. Эдгээр бэрхшээлүүд нь боловсрол, нийгэм сэтгэл зүйн дэмжлэг, АЦХ-ийн олдоц эсвэл УАЦЭА-ийн байгууламжийн нөхцөл зэрэг биет орчинтой холбоотой байна. Охид сарын тэмдэг ирэхэд сэтгэл санааны хувьд болон зан үйлийн хувьд юу мэдэрч байсан тухайгаа ярьснаас гадна, хэрвээ илүү дэмжлэг сайтай орчинд байсан бол бүх юм өөр байх байсан гэж тэмдэглэн хэлжээ (жишээ нь: “ойр хавьд хүн байхгүй үед би хувцсаа угаадаг”, “Би ичдэг”).

### Бэлтгэлгүй байх

Ихэнх бага насны охид сарын тэмдэг анх ирэхэд ихэд хямардаг байна. Энэ талаар тодорхой хэмжээний мэдээлэлтэй байлаа ч яг ирсэн үед нь айж, цочролд ордог байна. Охидын дийлэнх нь сарын тэмдэг анх ирэхээс өмнө энэ тухай сонссон байдаг боловч зарим нь хэрхэн учраа олох талаар юу ч мэддэггүй байсан гэжээ.

- ***“Анх удаа миний биеийн юм ирэхэд би үхэж байгаа байх гэж бодоод уйлсан” (хотын захСЗ\_ОФБЯ\_2)***
- ***“Анх удаа сарын тэмдэг ирсэн үед би айчихсан, муухай санагдаад хэн нэгэн мэдчих вий гэж санаа зовж байсан” (АймагС8\_ОФБЯ\_2)***
- ***“Биений юм хугацаандаа ирдэггүй өөрчлөлттэй учраас ариун цэврийн хэрэгсэл авч явдаггүй”(С9\_ОФБЯ\_1)***

Сарын тэмдгийн мөчлөг нь тогтмол биш, бас АЦХ-ийн олдоц муутай учраас заримдаа бэлтгэлгүй ирдэг гэж зарим охид хэлжээ.

### Сарын тэмдэг ирснээ хөвгүүдээс нуух

Аав, ах, бусад эрэгтэй хүнтэй эсвэл дэргэд нь сарын тэмдгийн талаар ярих нь цээртэй зүйл хэвээр байна. Иймээс сургууль дээр хөвгүүдэд дооглуулж шоолуулах нь охидод сарын тэмдгийн эрүүл ахуйг зохицуулахад стресстэй, ичмээр байдалд хүргэдэг аж. Тэдний хувьд нэвтрэх, хувцас дээр толбо тогтох эсвэл АЦХ авч явааг нь хөвгүүд мэдэх зэрэгт санаа нь зовнидог. АЦХ-ээ хөвгүүдээс нуух нь охидын хувьд нэлээд ноцтой сэтгэл зовоосон асуудал байдаг гэжээ.

- *"Бидний хамгийн айдаг зүйл бол сарын тэмдэг ирснийг хөвгүүд анзаарах."* (С8\_ОФБЯ1\_2)
- *"Сандал цус болчихсон байвал хөвгүүд ажиглахаас өмнө цэвэрлэж байгаарай гэж манай багш хэлсэн"* (С6\_ОФБЯ\_2)
- *"Өөр ангийн хүүхдүүд хувцас нь нэвтэрчихсэн (цус) нэг охиныг шоолж байхыг харсан...тэр охин туйлын эвгүй байдалд орчихсон ичиж зовж байсан тохиолдлыг мэднэ."*(С3\_ХөвгүүдФБЯ)
- *"Хөвгүүд охидын цүхнийг нэгжиж, АЦХ байхыг олчихвол шоолох учраас, аль болох цүнхнийхээ нууц газарт хийх эсвэл сургууль дээр (АЦХ) огт авчирдаггүй."* (ХөдөөС9\_ОхидФБХ\_1)

### Нэвтрэх, толбо тогтох ба эвгүй үнэр гарахаас айх

Дотуур байранд эсвэл гэртээ байдгаас үл хамаарч хот ба хөдөөгийн бүх охидууд сарын тэмдэг ирсэн үеэр сургууль дээрээ байхдаа нэвтрэх, толбо тогтох эсвэл эвгүй үнэр үнэртэх зэргээс айж сэтгэл санааны дарамтад ордог гэжээ.

- *"Эвгүй үнэр үнэртэх вий гэж санаа зовоод найз хөвгүүнийхээ хажууд суухаас зугтаадаг."* (С3\_ОГЯ)
- *"Нэг удаа шалгалтын үеэр нэг охин ангиас гарах зөвшөөрөл багшаас авах гэсэн чинь зөвшөөрөөгүй, гэнэт банди нар нөгөө охиныг заагаад өмдөндөө шээчихэж гээд эхэлсэн... ичмээр байсан."*(С3\_ОФБЯ\_2)
- *"Хичээлийн дараа хөвгүүд анги цэвэрлэж байхдаа сандлуудыг нэг нэг рүү түлхэж зайчилж байхад цус болчихсон байхыг би харсан."*(С5\_БагшФБЯ)

### Тусламж гуйхад хүндрэлтэй байх

Олон нийтийн дунд сарын тэмдгийн талаар ярих нь цээртэй хэвээр тул охидод хамгийн дотны найзуудаас өөр хэн нэгнээс энэ талаар туслалцаа эрэх нь хүндрэлтэй байдаг байна. Тэдний хувьд эрэгтэй багшаас ангиас гарах чөлөө гуйх, эсвэл дэлгүүрийн худалдагч нь эрэгтэй эсвэл ойр орчинд нь эрэгтэй хүмүүс байвал ичээд АЦХ худалдаж авч чаддагүй гэжээ.

- *"Бид нар голдуу багш нараасаа тусламж эрдэг, гэхдээ эрэгтэй багш байвал асуухад хэцүү байдаг."* (С6\_ОФБЯ\_1)
- *"Ялангуяа эрэгтэй багшаас жорлон орох чөлөө авахад хэцүү."*(С11\_ОФБЯ\_2)
- *"Охидууд ихэвчлэн сургуулийн эмчээс хэрэгсэл асуудаг, гэтэл сургуулийн эмчийн төсөв маш бага болохоор гурван уут хэрэглэл авч хүрдэггүй, иймээс заримдаа бид нар өөрийн мөнгөөр худалдаж авдаг."* (С3\_БагшФБЯ)

## Бие махбодид тохиолдох бэрхшээл

Бие махбодийн хувьд бас бэрхшээл учирдаг. Үүнд, хэвлийн доод хэсэг, нуруугаар болон толгой өвдөх, заримдаа толгой эргэх зэрэг ордог бөгөөд зарим охидод ямар нэг өвдөлт мэдрэгдэж байгаагүй байна.

Охидууд бариу дотуур өмд өмсөх эсвэл юм унших, кино үзэх, тоглоом тоглох зэргээр анхаарлаа өөр зүйлд төвлөрүүлж өвдөлтөө мартдаг бөгөөд ямар нэгэн эм уудаггүй гэжээ.

Сарын тэмдгийн мөчлөг нь тогтворгүй байдгаас охидууд сургууль дээрээ бэлтгэлгүй ирэх, нэвтрэх эсвэл толбо тогтоход санаа зовдог нь эргээд давхар бэрхшээлийг бий болгодог байна.



## Тодорхойлогч болон нөлөөлж буй хүчин зүйлс

Судалгааны ГЯ, ФБХ болон ГМЯ-д оролцсон охид, бусад оролцогчид сургуулийн орчинд сарын тэмдэг ирсэн үед охидод учирч буй гол хүндрэл бэрхшээлийг тодорхойлсон.

Түүнчлэн оролцогчид эдгээр хүндрэл яагаад охидод тохиолдож байгаа талаар өөрсдийн санал бодлоо хуваалцсан юм.

Эдгээр тодорхойлогч зүйлсийг дор нэгтгэн харууллаа:

1. Сургууль болон дотуур байрны УАЦЭА-н байгууламж шаардлага хангаагүй
2. Мэдлэг, мэдээлэл ба боловсрол
3. Сарын тэмдэг ирсэн үед яаралтай хэрэглэх материалын хүртээмж
4. Нийгэм сэтгэл зүйн дэмжлэгт орчин
5. Биологийн хүчин зүйлс

### Тодорхойлогч хүчин зүйл 1. Сургууль болон дотуур байрны УАЦЭА-н байгууламж тааруу

Сурагчид сургууль дээрээ олон цагийг өнгөрөөдөг тул биет орчин болон ариун цэврийн байгууламжийн цэвэр цэмцгэр байдал нь тэдний эрүүл мэнд ба сэтгэл санаанд чухал нөлөө үзүүлдэг. Сургууль УАЦЭА-н байгууламж сайтай байх нь сурагчдад, аюулгүй, эрүүл бөгөөд тохитой орчинд амжилттай суралцах орчныг бүрдүүлэх төдийгүй сургуульд явах урам зоригийг нь дэмжиж байдаг.

#### *Ихэнх сургуулийн бие засах газрууд УАЦЭА-н стандарт шаардлагад нийцээгүй*

Монгол Улсын Засгийн газраас 2015 оны эхээр баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага”-д 30 охидын дунд нэг суултуур; 40 хөвгүүдийн дунд нэг суултуур дээр нь нэг шээлтүүр байхаар заажээ<sup>14</sup> (Хавсралт 2-ыг хар).

Улаанбаатар хотод сонгосон хоёр сургууль (нэг нь хотын төвийн, нөгөө нь хотын захын гэр хорооллын) нь өдөрт гурван ээлжээр хичээллэдэг буюу нэг ээлжинд хичээллэж буй 5б-6б охидын дунд нэг жорлон ногддог байна. Ийм нөхцөлд бие засах газрыг цэвэрхэн, бүрэн бүтэн байлгах нь маш их асуудалтай юм. Судалгаанд хамрагдсан сургуулиудаас хүүхдийн тоо цөөхөн байдаг

<sup>14</sup> Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага. 2015 он БСШУЯ, СЯ, ЭМСЯ.

Улаанбаатар хотын алслагдсан дүүргийн нэг сургууль болон хөдөөгийн сумдын сургуульд ус, ариун цэврийн байгууламжийн тоо нь стандартын шаардлагыг хангаж байв. Сурагчдын тоо сургуулийн барилга, анги болон УАЦЭА-н байгууламжийн хүчин чадлаас давсан үед хүүхдүүд хичээлийн цагаар сургуулийн бие засах газрыг ашиглах нь хүндрэлтэй байдаг аж.

- *"Дотуур байрны хүүхдүүд харанхуйд (охид АЦХ-ээ солихдоо) тэгээд яаж ийж байгаад нэг юм болдог л байх даа." (С9\_ЭэжФБЯ)*
- *"Сургуулийн 00 эрэгтэй, эмэгтэй тусдаа. Гэхдээ дотроо гэрэлгүй, тоггүй. Хогийн савгүй, гар угаах газаргүй. Цэвэрлэдэг хүн байдаггүй, үнэртэй, бохир, хаалгагүй, ариутгал хийдэггүй." (С9\_ОФБЯ)*

*Хот, аймаг болон сумын сургуулийн бие засах байгууламжийн харьцуулалт*

**Зориулалт.** Нийт бие засах газрын 40 орчим хувийг охид, эмэгтэй багш нар харин сумын сургуулийн жорлонгийн 18 хувийг охид, хөвгүүд аль аль нь ашигладаг байна. Зөвхөн багш нар ордог цөөн тооны бие засах газар цоожтой байв. Дээр дурьдсанаар, хөдөө сумын сургуулиудын ихэнх нь энгийн нүхэн жорлонтой байна. Зарим бие засах газар цоожтой буюу ажиллагаагүй тул "мэдэхгүй" эсвэл "хамааралгүй" ангилалд багтаасан (Хавсралт За харах).

*"Хөвгүүд, охидын 00 тусдаа ч гаднаа эрэгтэй, эмэгтэй гэсэн бичиггүй болохоор надад лав бие засах үед хэн нэгэн гэнэт ороод ирэхээс сэтгэл зовоод, эвгүй санагддаг. (С8\_ОФБЯ\_2)*

**Ажиллагаатай байдал.** Судалгааны үеэр ажиглалтаар цуглуулсан тоо баримтаар, сонгон авсан нийт сургуулиудын ариун цэврийн өрөөний зөвхөн 42 хувь нь бүрэн ажиллагаатай байхад 14,5 хувь нь цоожтой байсан тул үнэлэх боломжгүй байлаа. Дотуур байрны хувьд зөвхөн 24 хувь нь бүрэн ажиллагаатай байхад 15 хувь нь ажиллагаагүй байв (Хавсралт За, ЗБ).

Хөдөөгийн сумдын сургуулийн жорлонгийн бараг 40 хувь нь ажиллагаагүй байхад хотын сургуулиудын хувьд энэ нь ойролцоогоор 10 хувьтай байна. Иймд хэдийгээр жорлон байгаа ч хаалгагүй (эсвэл дотроо түгжээгүй) гэрэлгүй эсвэл хогийн савгүй тул эдгээрийг бүрэн ажиллагаатай гэж үзэх боломжгүй учир нь хүүхдийн, ялангуяа охидын хувьд аюулгүй, тавтай байх орчин бүрдээгүй байна үзлээ.

Сургуулийн бие засах газрын байрлал болон цонхны хаалт нь мөн л анхаарал татсан асуудал юм. Хотын нэгэн сургуулийн охид ярихдаа, нэг давхарын бие засах газрын жорлонгийн цонх нь хөшиггүй тул хэн ч дээд давхрын цонхноос доош өнгийн харах боломжтой, иймээс тэнд орох дургүй тухайгаа судлаачдад хэлжээ.

Зураг 9 ба 10. Хөдөөгийн сургуулийн (сумын) нүхэн (А) ба хотын сургуулийн (Б) татуургатай жорлонгийн харьцуулалт



А.

Б.

Эх үүсвэр: НАХТ, Улаанбаатар хот

Цэвэр байдал. Судлаачдын ажиглалтаар, хотын сургуулиудын 65 хувь<sup>15</sup>, харин аймгийн төвийн сургуулийн 29 хувь, сумын сургуулийн зөвхөн 20 хувь нь тус тус эрүүл ахуйн шаардлага хангасан бие засах газартай байна. Түүнчлэн бие засах газрын бараг тал орчим хувь нь муухай үнэртэй, ялаатай, шал болон хогийн сав нь бохир эсвэл хогийн савгүйгээс хаа сайгүй хог хаясан тул “бохир” хэмээн үнэлэгджээ. Иймээс ихэнх сурагчдын хувьд сургуулийн жорлон ашиглахаас аль болохоор зайлсхийн, хичээл тараад гэртээ очтолоо тэвчдэг ба дотуур байрны хүүхдүүд байрныхаа бие засах газраа ашигласан нь дээр гэж үздэг байна. Мөн сургуулийнхтай харьцуулахад дотуур байрны бие засах газар илүү дээр гэж олон охид хэлжээ. Зарим тохиолдолд УАЦЭА-н байгууламж хэтэрхий бохир тул хөвгүүд, бага ангийн хүүхдүүд гадаа бие засдаг байна.

Аймаг, сум, хотын бүх сургууль үйлчлэгчтэй. Тэд бие засах газрыг үнэргүй, хоггүй цэвэрхэн байлгах үүрэгтэй. Сургуулийн үйлчлэгч нар янз бүрийн цэвэрлэгээний материал, ялангуяа хүмүүсийн түгээмэл хэрэглэдэг, өргөн тархсан хлорамин зэрэг ариутгалын бодис ашигладаг байна. Сургуулийн жорлонг ихэнхдээ маш олон хүүхэд ашигладаг, нэг жорлонд ногдох хүүхдийн харьцаа хэтэрхий өндөр зэрэг шалтгааны улмаас сургуулийн жорлон заримдаа тийм ч цэвэрхэн биш, эвгүй үнэртэй байдаг гэж охид, ФБЯ-ын бусад оролцогчид тайлбарлажээ. Үүнээс гадна, үйлчлэгч нар өөрсдийн хариуцсан бие засах газраа амралтын өдрүүдэд цоожилдог, заримдаа хичээлийн цаг эхэлсний дараа онгойлгодог байна. Нэгдүгээр давхрын жорлон амралтын өдрүүдэд онгорхой байдаг болохоор хамгийн бохир байдаг гэжээ.

**“Сургуулийн үйлчлэгч цэвэрлэдэг ч (00-ийн өрөө) олон хүүхэд ашигладаг болохоор цэвэрхэн байдаггүй. Тиймээс бид нар ихэнхдээ сургуулийн 00-д ордоггүй.”(С8\_ОФБЯ\_1)**

<sup>15</sup> НҮБ-ын Хүүхдийн Сан, “Сургуулийн орчинд УАЦЭА-н байдлыг хянах үнэлгээний багц”-д тодорхойлсноор үнэргүй, байгууламжийн эргэн тойронд эсвэл дотор нь нүдэнд харагдах баасгүй, хоггүй, ялаа эсвэл хоггүй

**Гэрэлтүүлэг.** Хотын сургуулийн 5 хувь, аймгийн төвийн сургуулийн 25 хувь, хөдөө сумын сургуулийн нүхэн жорлонгийн 75 хувь нь гэрэлгүй байна. Энэ байдлаас охидод энгийн үед бие засахад ч хүндрэлтэй байдаг бол, ариун цэврийн хэрэгслээ солих гэвэл бүр ч их бэрхшээлтэй болдог байна. Шөнийн цагаар жорлон ашиглах нь ч эрсдэлтэй байж болох талтай.

***"Дотуур байрны хүүхдүүд харанхуйд хэн нэгнийг гуйж хамт гарч бие засна."***  
(C9\_ОФБЯ\_2)

Дотор талын түгжээ нь охидын нууцлалыг хангахад маш чухал билээ. Хөдөөгийн сургуулиудын бие засах газрын зөвхөн 26 хувь нь дотроо түгжээтэй бөгөөд түгжээний 18 хувь нь хэвийн ажилладаг байхад хотын сургуулиудын хувьд эдгээр үзүүлэлт нь 81 ба 61 хувь; харин аймгийн төвийн сургуулиудын хувьд 69 ба 41 хувьтай байна. Ихэнх охидын бодлоор сургууль дээр хувцсаа солих, угаах эсвэл ариун цэврийн хэрэгслээ солих хувийн орон зай байхгүйд сэтгэл гонсгор байдаг гэжээ.

- ***"Санаа амар бие засах боломжгүй болохоор бид нар голдуу сургууль дээр 00 орохгүй байхыг боддог."***(C5\_ФБЯ\_2)
- ***"Жорлонгийн хаалга түгжээгүй болохоор хэрэгслээ солиход хэцүү байдаг."***  
(C4\_ОФБЯ\_2)
- ***"Сургууль дээр сольдоггүй. Өглөө гэртээ солиод ирдэг. Тэгээд өдөр гэртээ очоод сольдог."*** (C9\_ОФБЯ\_2)

Сургуулийн жорлонд нууцлал хангах нөхцөлгүй тул охид бие засах газар луу явахдаа найз нараасаа дагуулж явдаг байна. Хотын сургуулиудын 76 хувь, аймгийн төвийн сургуулиудын 44 хувьд нь охид сургуулийн жорлон ашиглахдаа найз нөхдөө дагуулж явах шаардлагагүй байдаг.

***"Хэрвээ бид нар 00 руу явахаар бол найзыгаа хаалга даруулахаар авч явдаг."*** (C4\_ОФБЯ\_2)

Ариун цэврийн өрөөний хогийн савны хүртээмж нь хотын сургуульд 92, аймгийн төвийн сургуульд 74, харин сумдын сургуульд 26 хувьтай байна. Ийнхүү хогийн савны хүртээмж муугаас охид сургууль дээр сольсон хэрэгслээ хаях газар олдохгүй эвгүй байдалд ордог байна. Эндээс үзэхэд, хөдөөгийн болон дотуур байрны охид хэрэглэсэн хэрэгслээ цаасанд ороож жорлон руу эсвэл шалан дээр хаяхаас өөр сонголтгүй болдог байна. Хотын сургуулийн ихэнх жорлон хогийн савтай байдаг ч голдуу дүүрчихсэн байдаг тул ямар ч хэрэгцээгүй гэж ФБЯ-ын оролцогчид мэдээлжээ.

*Хот ба аймгийн төвийн дотроо татуургатай жорлонтой УАЦЭА-н байгууламж*

Хүснэгт 6-аас харахад хотын сургуулийн 95 хувь нь усан татуургатай дотуур жорлонтой байхад хөдөө сумдын сургуулийн 90 хувь нь энгийн нүхэн жорлонтой байна.

*Хүснэгт 6. Хот, аймаг болон сумын сургуулийн бие засах байгууламжийн төрөл*

Ажиглалт	Хариу	Хотын сургууль		Аймгийн сургууль		Сумын сургууль	
		Жорлонгийн тоо. N=79	%	Жорлонгийн тоо. N=77	%	Жорлонгийн тоо. N=65	%
Бие засах байгууламжийн төрөл	Усан татуургатай	75	95%	65	81%	7	11%
	Нүхэн жорлон	4	5%	8	10%	52	80%
	Сайжруулсан, агааржуулагчтай нүхэн жорлон	0	0%	3	4%	5	8%
	Мэдэхгүй/ХА	0	0%	1	5%	1	2%

Сургуулийн усан татуургатай жорлонгийн усны даралт бага үед дараагийн хүүхдэд мэдэгдэхгүйн тулд гоожсон цусыг урсаж дуустал нь хэд хэдэн удаа татуургыг татах болдог нь охидын санааг зовоодог байна. Энэ нь охид сарын тэмдэг ирснийгээ бие биенээсээ нуудаг; эсвэл жорлонгийн ёроолд цус үлдээсэн буюу цэвэрхэн байсангүй гэж бусад хүүхдүүд буруутгахаас айдгийн илрэл юм.

Хөдөөгийн сургуулиудад, ялангуяа сумдад, охидын болон хөвгүүдийн бие засах газар тэр бүр тусдаа байдаггүй. Зарим үед, гадаах жорлонгийн бүхээгийг хооронд нь энгийн банзаар тусгаарлаж охидын болон хөвгүүдийнх гэж ялгасан байдаг. Заримдаа оройн цагаар (охид хичээлээс гадуурх ажилд оролцох үед) сургуулийн бие засах газар хаалттай бол хөвгүүдийнх байсан ч хамаагүй аль онгорхой жорлонд орохоос өөр аргагүй байдал охид ордог.

**“Би нэг удаа (хөвгүүдийн 00-д) орсон чинь манай сургуулийн багш бие засаж байсан” (ХотС1\_ОхидФБХ+2)**

*Аймгийн төвийн сургуулийн УАЦЭА-н байгууламж*

*Зураг 11. Гадаах нүхэн жорлон*



*Эх үүсвэр: НАХТ*

Аймгийн төвийн сургуулиудад дотор ба гадна жорлонгийн аль аль нь байдаг. Дотор байрласан байгууламжийн хувьд угаалтуур нь жорлонтойгоо ойр тул сурагчид бие зассаны дараа шууд гараа угаах боломжтой. Сурагчдын хэлснээр, бохирыг соруулах, цэвэрлэх зардал нэмэгдэнэ гэж сургуулийн удирдлага ихээхэн санаа зовдог тул дотор жорлон ихэнхдээ цоожтой, хүүхдүүд гадаах жорлонг ашиглахаас өөр аргагүйд хүрдэг. Аймгийн төвийн болон сумын сургуулийн гадаах нүхэн жорлонгийн нөхцөл байдал ерөнхийдөө ижил байдаг байна.

Хөдөө сумын сургуулийн гадаах нүхэн жорлон бүхий УАЦЭА-н байгууламжийн нөхцөл

Ихэнх сумын сургууль болон дотуур байрууд гаднаа нүхэн жорлонтой бөгөөд хувь хүний нууцлалыг хангадаггүй. Бие засах бүхээг нь голдуу түгжээгүй, гэрэлгүй тул охидууд АЦХ-ээ солиход хүндрэлтэй байдаг. Үүнийг охид ярилцлагадаа баталсан билээ.



Сургуулийн гадаах нүхэн жорлонгийн нөхцөл байдал нь нэлэнхүйдээ тааруу. Тэдгээр нь голдуу хаалгагүй тул хувийн нууцлал хангагдахгүй, охид, хөвгүүдийнх тусдаа биш, бохир бөгөөд эвгүй үнэртэй, гэрэлгүй, хүйтэн цаг уурын нөхцөлд цэвэрлэх боломжгүй тул өвлийн цагт цас мөстөж, хальтиргаа ихтэй байдаг. Зураг 11-т хөдөөгийн сургуулийн ердийн жорлонг харуулж байна. Эдгээрийг намар, хавар эсвэл зуны эхэн сард ашиглахад амар боловч дулаалга, халаалтгүй тул өвлийн цагт ашиглахад тохиромжгүй.

Ихэнх сумын сургууль, дотуур байранд ус хангамжийн систем байхгүй тул хөвгүүд ахуйн ба ундны усаа худгаас эсвэл усан сангаас ачааны машин, үхэр тэргээр зөөдөг байна.

*Зураг 12. Сумын сургуулийн усыг үхэр тэргээр зөөж байгаа нь*



*Эх үүсвэр: НАХТ*

Сургуулиуд ажиллагаатай бие засах газаргүй байгаагийн гол шалтгаан нь УАЦЭХ-н байгууламж сайтай байхын ач холбогдлын талаар удирдлагуудын ойлголт хангалтгүй, тиймээс эдгээрийг сайжруулах асуудалд анхаарал сул тавьдагт оршиж байна. Жишээ нь, судалгаа эхлэхээс жилийн өмнө нэгэн сумын сургууль өөрийн 60 жилийн ойг угтаж босгосон хуримтлалын сангийн мөнгөөр хөрөнгө оруулалтын 60 төслийг хэрэгжүүлжээ. Гэтэл ганцхан зүйлд хөрөнгө хүч зориулаагүй нь бүрэн засвар хийх цаг нь аль хэдийнэ болчихсон сургуулийн бие засах газраа сайжруулахад л мөнгө зарцуулаагүй байжээ. ФБЯ-ын үеэр, одоогийн байгаа жорлонг сайжруулах ямар ч аргагүй, шинээр барих нь зүйтэй гэж охид хэлжээ.

Зарим сургуульд зөвхөн багш нарт зориулсан бие засах газартай түүнийгээ цоожилдог тул хоёр дахийг нь бүх охид, хөвгүүд аль аль нь хэрэглэдэг байна (Зураг 13).

Зураг 13. Аймгийн төвийн сургуулийн сурагчдын бие засах газар



Зураг 14. Багш нарын бие засах газар



Эх үүсвэр: НАХТ

Зураг 15, 16. Мөрөөдлийн ариун цэврийн өрөө



#### Мөрөөдлийн ариун цэврийн өрөө


Судалгаанд хамрагдсан бүх сургуулийн охид мөрөөдлийн ариун цэврийн өрөөний тухай бодлоо хуваалцсан. Тэдний төсөөллөөр охид ба хөвгүүдийн жорлон нь тусдаа, дотроо түгжээтэй, хувцсаа харах тольтой, цүнх өлгөх өлгүүртэй, гар утас зэрэг хувийн эд зүйлсээ тавих тавиуртай байх хэрэгтэй гэжээ. Мөн сургуулийн жорлон татуургатай бөгөөд ажиллагаатай, жорлонгийн өрөөн дотроо АЦХ, ариун цэврийн цаас болон савантай, бие засах газар нь цэвэрхэн, эвгүй үнэргүй, гар угаах угаалтуур, хогийн сав болон гар хатаагчтай байх нь зүйтэй гэжээ (Хавсралт 4а, 4б, 4в).

Охидын ФБЯ-аар (Зураг 15) эн тэргүүнд жорлон цэвэрхэн, агааржуулалт сайтай бөгөөд охид ба хөвгүүдийнх гэж тусдаа байхыг чухалчлан үздэгээ онцолсон байна (СЗ\_ОФБЯ\_2). Зургийн дээд хэсэгт охидууд одоо байгаа ариун цэврийн өрөөний хаалгыг, харин доод хэсэгт нь тэдний мөрөөдлийн ариун цэврийн өрөөний зургийг зурж, сургуулийн сурагчдын тоонд таарсан хангалттай тоотой байх нь зүйтэйг анхаарах хэрэгтэй гэжээ.

#### Хөдөөгийн сургуулийн гар угаалтуур

Хотын болон аймгийн төвийн сургуулиуд голдуу дотроо ариун цэврийн өрөөтэй, угаалтуур зэрэг орчин үеийн УАЦЭА-н байгууламжтай байна. Гэвч сумдын ихэнх сургууль, дотуур байрны бие засах газрын ойролцоо саван бүхий гар угаах байгууламж үгүй байна. Иймээс сурагчид бие зассныхаа дараа энгийн гоожуурт гараа угаахаар анги руугаа эсвэл дотуур байрныхаа өрөө рүү явдаг ажээ.

Зураг 17. Хөдөөний сургуулийн энгийн гар угаалтуур



Эх үүсвэр: НАХТ

Хөдөөний сургуульд ус ховор тул жорлонд бие зассаны дараа эсвэл хоолны өмнө нойтон салфетка, Санитол зэрэг гар ариутгагч хэрэглэж гараа цэвэр байлгахыг сургуулиас нь зөвлөдөг байна.

**“Сургууль дээр угаах (нэвтэрсэн хувцсаа) боломж байхгүй.” (С11\_ОФБЯ\_2)**

#### Дотуур байрны охидын УАЦЭА-н байгууламж

Дотуур байрны охид хувцсаа угаах тусдаа өрөө байдаггүй тул бусад хүүхдийн хамтаар нийтийн угаалгын өрөөнд хувцсаа угаадаг. Тэд жижиг түмпэнд ойр зуурын жижиг зүйлсээ угаан, цус болсон хувцсаа амралтын өдрөөр гэртээ очих хүртлээ эсвэл улирлын амралтаар харихыг хүлээн хадгалдаг байна. Хөдөөний сургуулийн дотуур байр нь голдуу нүхэн жорлонтой, тохьгүй, нөхцөл нь хөдөөгийн сургуулийнхтай ижил байдаг. Хэдийгээр дотуур байрны сурагчид шүршүүрт орох боломжтой боловч хуваарийн дагуу долоо хоногт нэгээс хоёр удаа ордог байна. Хэрвээ өөрсдөө хүсвэл нийтийн буюу сумын халуун усны газарт орох боломж бас бий.

#### Хөдөөний сургуулийн халуун усны шүршүүр

Хөдөөгийн бүх сургуулийн дотуур байр (гэхдээ сургуульд бус) усанд орох өрөөтэй байх шаардлагатай. Энэ шаардлагыг ихэнх сургуулийн дотуур байранд сайтар мөрддөг бөгөөд хичээлийн жилийн хугацаанд, хуваарийн дагуу сурагчид сардаа хоёроос дөрвөн удаа шүршүүрт ордог байна. Гэхдээ сумын дөрвөн сургуулийн нэг нь засвар үйлчилгээний асуудлаас болж шүршүүр нь ажиллахгүй байсан. Энэ тохиолдолд сурагчид орон нутгийн буюу сумын нийтийн халуун усны газарт ордог.

#### Тодорхойлогч хүчин зүйл 2: Мэдлэг, мэдээлэл ба боловсрол

Судалгааны туршид судлаачид охидоос сарын тэмдэг анх ирэхээс өмнө энэ талаар мэдэж байсан эсэх, тэдэнд ямар төрлийн бэрхшээл хүндрэлтэй тулгардаг болон ямар мэдээлэл ба зөвлөгөөг хэнээс авч байсан талаар асууж тодруулсан. Хариултууд нь янз бүр байлаа.

#### Сургуулийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрт сарын тэмдгийн сэдэв ордоггүй

2011 оны 9-р сарын 28-ны өдрийн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 369 тоот тушаалаар, эрүүл мэндийн хичээлийг тавдугаар ангиас эхлэн сургалтын хөтөлбөрт тусдаа бие даасан хичээл болгон оруулж, нэг хичээлийн жилд 34-35 цаг буюу долоо хоногт нэг цагаар заахаар болжээ. Цөөхөн цагт маш олон сэдвийг багтаах шаардлагатай байв.

Саяхнаас Засгийн газар энэ шийдвэрийг хүчингүй болгож, 2015 оны хичээлийн жилээс эхлэн эрүүл мэндийн хичээлийг биологийн болон биеийн тамирын боловсрол олгох хөтөлбөртэй интеграцчилж оруулах болсон. Жишээ нь, бага ангид үздэг “Хүн ба Орчин” болон “Хүн ба байгаль” хичээлд эрүүл мэнд ба дасгал, хүний биеийн бүтэц, нөхөн үржихүй ба хөгжил зэрэг сэдвийг тусгажээ. Дунд ангийн сурагчдын судалдаг биологийн хичээлд хүний биеийн анатоми, физиологи, нөхөн үржихүйн эрхтний бүтэц болон нөхөн үржихүйн талаар үздэг. Биеийн тамирын хичээлд цаг уурын ялгаатай орчинд зөв хувцаслах, эрүүл аж төрөх, эрүүл хоол хүнс, дасгал болон таргалалт зэрэг сэдвүүд орсон байдаг.<sup>16</sup>

Энэхүү судалгаа нь эрүүл мэндийн хичээлийг биологи болон биеийн тамирын хичээлтэй нэгтгэхийн өмнөхөн хийгдсэн учир охид, хөвгүүдийн аль аль нь шилжилтийн нас болон эрүүл мэндтэй холбоотой бусад сэдвийг эрүүл мэндийн хичээлээр үзсэнээ хэлж байлаа. Хичээл нь тавдугаар ангиас буюу сурагчдыг 12 настай байх үеэс эхлэн долоо хоногт нэг цагаар ордог байсан байна.

- **“Шилжилтийн нас буюу хүний хөгжил, бэлгийн бойжилт эрт болчихсон гээд 5 дугаар ангиас нь энэ сэдвээр эхлээд өгч байгаа.”(С9\_ЭМбагш)**
- **“Шилжилтийн үеийн тухай бүх сэдвийг нэг цагт л үзсэн. Энд сарын тэмдгийн тухай ч орсон... Өө нэг их нарийн гүнзгий орохгүй.” (С9\_ЭМбагш)**

Сарын тэмдгийн талаар “шилжилтийн нас” сэдвийн дотор товчхон заасан гэдгийг охид баталсан юм. Нэлээд олон охид сарын тэмдгийн талаар, чухам юу болох, яагаад ирдэг болон хэрхэн арчлах талаар юу заалгаснаа санахгүй байхад зарим бүлгийн охид маш ерөнхий мэдээлэл авснаа дурдаж байв.

Магадгүй энэ нь хөвгүүд ба охид эрүүл мэндийн хичээлд хамт ордог, багш нар энэ талаар нээлттэй ярьж сурагчдаа эвгүй байдалд оруулахыг хүсэхгүй байх; түүнчлэн хөвгүүд ба охид бие биенийхээ өмнө энэ асуудлын талаар илэн далангүй ярихад ичиж зовдог зэргээс шалтгаалдаг байж болох юм.

- **“Эрүүл мэндийн хичээл дээр тодорхой хэмжээний мэдлэгтэй болж байгаа... харилцаа, шийдвэр гаргах, жирэмслэлтээс хамгаалах гэсэн сэдвүүд ордог.”(С9\_ОФБЯ\_ГГЯ\_1)**
- **“...Биеийн юмны талаар тийм бие даасан сэдэв гэж байхгүй (эрүүл мэндийн хичээл). Зүгээр л нэг сэдвийн дунд хавчигдаад л ордог...Биений юмтай холбоотой мэдээллийг ер нэг их тогтмол авч чаддаггүй.. хааяа л, одоо ер нь тэр ганц цаг дээрээ л мэдээллийг авна.”(С9\_ЭМбагш)**

Зарим эрүүл мэндийн хичээлийн багш нар хичээлийн цаг хангалтгүй, бас сурах бичгийн чанар муутай зэргээс энэ хичээлийг заахад хүндрэлтэй гэж цохон хэлж байв.

Хэдий тийм боловч, эрэгтэй, эмэгтэй сурагчдын мэдээлснээр сарын тэмдэг болон шилжилтийн настай холбоотой сэдвүүдийг 5-р ангийн хөтөлбөрт товчхон дурьддаг, бусад ангид хичээлийн үндсэн агуулга өөр тул тусгадаггүй байна. Ангийн багш нар голдуу сарын тэмдгийн биологийн явцын талаарх мэдээлэл өгөхөөс хэрхэн арчилж зохицуулах болон эрүүл ахуйн талаас нь заадаггүй байна.

<sup>16</sup> Эрүүл мэндийг байгалийн ухаантай нэгтгэх нь шинэчлэл мөн үү?, 2015 оны 2 сарын 6, Зууны мэдээ : [www.Zms.mn](http://www.Zms.mn); <http://www.polit.mn/content/59229.htm>.

*Сарын тэмдгийн тухай охидын мэдлэг ба ойлголт*

Сарын тэмдгийн талаарх охидын мэдлэг ба ойлголт нь ялгаатай байна. Ихэнх бага насны охид сарын тэмдэг анх ирэхээс өмнө энэ тухай мэдээллийг ээж нараасаа эсвэл эрүүл мэндийн багшаасаа голдуу мэдэж авсан гэжээ. Хамгийн анх авсан мэдээлэл нь маш товчхон, зөвхөн биологийн үйл явц, нөхөн үржихүйн эрхтнүүд болон шилжилтийн үеийн шинж тэмдэгтэй холбоотой байжээ.

Охид яагаад эмэгтэй хүнд сарын тэмдэг ирдэг, сарын тэмдэг гэж юу болох, хэр удаан хугацаатай ирэх, давтамж нь хэр ойрхон байх талаар бүрхэг ойлголттой байна. Сарын тэмдэг анх ирэх үед тэд цочирдож, айдаг байна. Зарим тохиолдолд, тухайн орон нутагт олон жилээр уламжилж ирсэн итгэл үнэмшил охидод нөлөөлдөг аж. Жишээ нь, нэг ФБЯ-ын үеэр зарим охид нь сарын тэмдэг бол биед явагдаж байгаа шилжилтийн үеийн онцлог, биед гарч буй өөрчлөлтийн нэг хэсэг гэж тайлбарлаж байхад нөгөө хэсэг нь биенээс “бохир цус” гадагшилж, бие цэвэршиж буй хэрэг гэж ээж, эмээ нар нь хэлж өгсөн гэжээ.

Эдгээр ам дамжин уламжлагдаж ирсэн домог шиг яриа байсаар байгаагийн шалтгаан нь сарын тэмдэг нь эмзэг сэдэв тул ээж нар охиддоо энэ тухай илэн далангүй ярихад амаргүй тул эл хууч яриаг ашигладаг, эсвэл өөрөөр хэрхэн сайн тайлбарлах аргаа мэддэггүй, эсвэл энэ буруу ойлголт одоо хүртэл хүмүүсийн дунд амь бөх оршоор байгаатай холбоотой байж болох юм.

- **“Сарын тэмдгийн үеэр биений муу цус нь гараад бие цэвэршдэг.” (C1\_ сургуулийн тайлан)**
- **Муу цус гадагшлаад тэгээд л биений юм ирдэг гэж (ээж) хэлж байсан.”(C9\_ ОГГЯ\_1)**

*Сарын тэмдгийн талаарх охидын ойлголтод нас хамааралтай нь тод харагдаж байлаа.*

Ахлах ангийн охид сарын тэмдгээ зохицуулж сурсан, найз охидтойгоо туршлагаа хуваалцдаг тул илүү үнэн зөв мэдээлэлтэй байх магадлал ихтэй байна. Охидын бодлоор эрүүл мэндийн хичээлээр сарын тэмдгийн тухай үзэх үед тэд сарын тэмдгээ аль хэдийн сайтар зохицуулаад сурчихсан байдаг гэжээ. Иймээс ийм боловсролыг 5 эсвэл 6 дугаар ангид байхад нь буюу сарын тэмдэг анх ирэх үед өгөх нь зүйтэй гэж үздэг байна.

Бага насны охид нь сарын тэмдгийн талаар тодорхой ойлголтгүй, өөрсдийн мөчлөгийг тэмдэглэх тухай ярих ямар ч боломжгүй байв. 12-13 насны ихэнх охид сарын тэмдгийн мөчлөгийн календарь хөтөлж мэдэхгүй байхад 14-өөс дээш настай охид нуруугаар эсвэл хэвлийн доод хэсгээр өвдөх зэрэг биед илрэх шинж тэмдгээ ажиглан ирэх хугацаагаа урьдчилан тооцож сурсан байна. Гэхдээ тэдний ажигласнаар сарын тэмдэг ирдэг болсноос хойш жил хагас эсвэл хоёр жилийн дараа мөчлөг нь тогтвортой болсон гэж ярьж байв. Ийм шалтгааны улмаас охидууд АЦХ бэлэн байх нь дээр гэж үздэг байна.

Сарын тэмдгийн талаар мэддэггүй охид сургууль дээрээ бэлтгэлгүй ирэх нь олонтаа тул найз нараасаа зээлдэг байна. Ахлах ангийн охидууд сургуулийнхаа эмэгтэй эмч, багш, ээж болон эгч нараасаа асуух, энэ талаар ярихдаа ичиж зовдоггүй байна.

Судалгааны туршилтын үеэр, охидын ФБЯ-д оролцож байсан хотын захын сургуулийн сурагч, сарын тэмдэг анх ирэхийн өмнө ээж, эгчээсээ сарын тэмдэг, АЦХ-ийн талаар сонссон байсан ч яг ирсэн үед нь яаж зөв хэрэглэхээ мэдэхгүй байсан бөгөөд дараа нь зурагтаар харж ойлгосноо хэлсэн.

### *Ээж, эгч нараас авч буй дэмжлэг ба мэдээлэл*

Охидын хувьд тэдэнд тусламж хэрэгтэй болох эсвэл шилжилтийн нас, бүр сарын тэмдэг анх ирэхээс ч өмнө сарын тэмдгийн тухай мэдээлэл хэрэгтэй бол хамгийн түрүүнд ээждээ ханддаг байна. Ээж нар сарын тэмдэг гэж юу болох, аль насанд ирж болох, тэр үед юу хийх, хувийн эрүүл ахуйгаа хэрхэн сахих, тэр байтугай, ариун цэврийн хэрэгслийг яаж хэрэглэх талаар охиддоо тайлбарлаж өгдөг байна.

Дээр дурьдсаны дагуу, ээж нар сарын тэмдгийн талаар охиддоо “бохир цус” эсвэл “муу цус” зэрэг буруу мэдээлэл өгсөн тохиолдлууд ч байна. Эдгээр буруу мэдээллийн нийтлэг шалтгаан нь өмнөх үе үеэс уламжлагдан ирсэн мэдлэг ба туршлагад суурилсан сөрөг ойлголт юм. Иймээс зарим охид өөрийнхөөрөө дүгнэлт хийсэн байлаа.

- **“Муу цус буюу өвчтэй цус (сарын тэмдгийн үеэр) биеэс гараад, эргээд эмэгтэй хүний цус нь шинэчлэгддэг болохоор эмэгтэй хүн эрэгтэй хүнээс урт насалдаг. Эрэгтэй хүмүүсийн цус амьдралдаа ингэж сэлбэдэггүй болохоор урт насалдаггүй.” (С7\_ОФБЯ\_2)**
- **“Хөвгүүдийн биеэнд бохир цус нь тэр хэвээрээ байдаг болохоор харахаар надад өрөвдмөөр санагддаг.” (Туршилтын сургууль, УБ)**

Ээж нар нь хувийн эрүүл ахуйн талаар онцлон сарын тэмдгийн үед өдөр бүр угааж байхыг сануулж байсан гэж хотын сургуулийн охид хэлж байв. Гэсэн хэдий ч хөдөөний сургуулийн охидод сарын тэмдэг ирсэн үед голын усанд орж болохгүй (уламжлалт заншлаар бол гол, нуур эсвэл булгийн усанд цус эсвэл сүү дусаан бохирдуулж болохгүй гэж сургадаг) гэж зөвлөж байсан, зарим нь халдвар авахаас сэргийлж байн байн шүршүүрт орж болохгүй хэмээн ээж нар нь хэлж байсан гэжээ.

Ээж эгч нарынхаа зөвлөж хэлсний дагуу, хэтэрхий их хөдлөх эсвэл биеийн хүчний ажил хийвэл цус ихээр гарч, хувцас нэвтэрч магадгүй гэдэгт охид итгэдэг байна. Гэвч нэг тохиолдолд, сарын тэмдэг ирсэн үед спортоор хичээллэж болохгүй гэж эмч хатуу сануулахдаа чухам яагаад гэдгийг нь тайлбарлаж өгөөгүй гэж нэгэн охин ярьсан байна. Нэг хэсэгтээ тэр зөвлөгөөг нь дагаж байснаа, нэг удаа яах ч аргагүй тэмцээнд оролцсоны дараагаар эрчимтэй биеийн хүчний ажил хийхэд цус ихээр гардаг болохыг ойлгож авчээ.

Ээж нараасаа гадна охид сарын тэмдгийн талаар эгч нараасаа, бусад эмэгтэй хамаатан, найз нараасаа мэдэж авч, энэхүү мэдээлэл, өөрийн туршлагаа найз нартайгаа хуваалцдаг байна. Дээрээ эгчтэй охидууд сарын тэмдгийн талаар илүү сонсож мэдсэн байх талтай, мэддэг зүйлээ найз нартаа хэлж өгдөг байна.

Хотын сургуулийн охид сарын тэмдэг ба шилжилтийн насны талаар фейсбүүк гм нийгмийн сүлжээний хэрэгслээр сурч мэддэг байна.

### *Хөвгүүдийн мэдлэг ба дэмжлэг*

Сонгон авсан зургаан сургууль дээр хөвгүүдийн дунд ФБЯ хийсэн. Хот, хотын захын болон хөдөөгийн сургуулийн ахлах ангийн, эрүүл мэндийн хичээлд суусан сурагчид оролцсон тул сарын тэмдгийн талаар бага зэрэг ойлголттой, зарим нь үр тогтолт, нөхөн үржихүйн тухай эрүүл мэндийн хичээлээр үзсэн тул шинжлэх ухаанч нэлээд өвөрмөц ойлголттой байлаа. Гэхдээ, ярилцлагын үеэр хөвгүүд инээх, хажуу тийшээ харах, бие биенээ даажигнах зэргээр аашилж байв.

Дунд ангид байхдаа сарын тэмдгийн талаар мэддэггүй байсан үедээ охидыг шоолдог байснаа тэд хүлээн зөвшөөрч байлаа.

***“Урьд нь тэгдэг байсан, одоо бол охидыг шоолохоо больсон. Бараг тавдугааар анги орчим арай жоохон байхад тайлбарлаж өгсөн бол тэгж охидыг шоолохгүй байсан.”(С11\_ ХөвгүүдФБЯ)***

Хөвгүүдтэй хийсэн ФБЯ-ын үеэр судлаачид сарын тэмдгийн үеэр охидод ямар байж болох талаар туршилтын дасгал хийсэн. Хичээл дээр сууж байтал тохойноос чинь гэнэт цус гарч эхэллээ гэж төсөөлөн бодоод ямар санагдах, юу хийх вэ гэж хөвгүүдээс асуусан. Дараахан нь охидод ямар хэцүү байдгийг нь ойлголгүй, шоолж байсандаа тэд харамсаж байгаагаа хүлээн зөвшөөрсөн.

Охидын хувьд сарын тэмдэг ирснийг хөвгүүд мэдэх, шоолуулж магадгүй гэдгээс хамгийн ихээр айдаг. Түүнчлэн хувцас нь нэвтэрчихвэл бүр муухай юм зүйл болно гэж боддог. Гэхдээ бага насны хүүхдүүд ингэж магадгүй, харин бид нар ийм зүйл хийхгүй гэж ахлах ангийн хөвгүүд хэлж байв. Хөвгүүд ахлах ангид орохдоо илүү ойлгон, даажигнах, шоолохоо зогсдог гэдэгтэй охид санал нийлж байлаа. Түүнчлэн, ахлах ангийн зарим хөвгүүд тэдэнд ямар ч хамаагүй гэж үзэж, анхаарч тоодоггүй байна.

***“Хөвгүүд өсөхийн хэрээр тэдний хандлага өөрчлөгддөг. Охидыг шоолохоо больж, маш их дэмждэг болдог, охидод тусламж хэрэгтэй үед туслахад бэлэн байдаг.” (С2\_ ОФБЯ\_2)***

#### *Сургуулийн багш нарын дэмжлэг*

Нийт сургуулийн багш нарын 70-90 хувийг эмэгтэй багш нар эзэлдэг (Хавсралт 5-аас дэлгэрэнгүй мэдээлэл харах). Иймээс сургуулийн орчинд охидын сарын тэмдэг ирсэн үед тэдэнд тусламж үзүүлж чадах насанд хүрсэн гол хүмүүс нь эмэгтэй багш нар юм. Охид бие засах өрөө явах зөвшөөрөл эсвэл ариун цэврийн илүү хэрэгсэл асуух зэрэгт голдуу эмэгтэй багш нартаа хандан тусламж авдаг байна.

***“Над дээр хоёр охин ирээд, нэгнийх нь өмд нэвтэрчихээд хэцүү асуудалтай болчихлоо гэсэн. Би тэднийг 00 руу дагуулж очоод, ариун цэврийн хэрэгсэл өгсөн. Тэгээд сарын тэмдгийн талаар тайлбарлаж өгөөд хэрэгслээ яаж хэрэглэхийг зааж бас хэлж өгсөн. Нөгөө охин нь гайхаад “Надад бас ирэх үү?” гэж асуусан. Тэр хоёр зургаа дугаар ангийнхан байсан.” (С10\_ БагшФБЯ)***

Хэдийгээр ховорхон боловч, цөөн тохиолдолд эмэгтэй багш нар хүртэл чухал хичээлээс хоцорчихно гээд охидод ангиас гарах чөлөө өгөх дургүй байдаг гэжээ. Заримдаа охидууд ангийнхаа бүх хүүхдийн өмнө ариун цэврийн өрөө орох шалтгаанаа хэлж чаддаггүй тул, багш нар худлаа ярьж зугаацах гэж байна гээд анхаарч үздэггүй байна.

**“Хүн бүрт (эмэгтэй хүн бүр) сарын тэмдэг ирэх нь хэвийн зүйл. Өсөж томроод насанд хүрсэн үед сарын тэмдэг ирлээ гээд ажлаа тасалж болохгүй шүү дээ. Үүний нэгэн адилаар сарын тэмдэг ирсэн үедээ сурагчид хичээл тасалж болохгүй.”(С\_10 БагшФБЯ)**

Эмэгтэй багш нартай харьцуулахад эрэгтэй багш нар сарын тэмдэг ирсэн үеийн охидын байдлыг ойлгодоггүй тул эрэгтэй багшид хандахад эвгүй санагддаг гэж охид боддог ажээ. Эрэгтэй багш нар, бас охидын аль алиных нь ийм хандлага нь бүх эрэгтэй хүнээс сарын тэмдгийн талаар нуух нь зүйтэй гэсэн хуучны итгэл үнэмшлээс угшилтай юм.

*Сургууль, дотуур байрны туслах ажилтны ойлголт дутмаг*

Сургуулийн үйлчлэгчид, дотуур байрны жижүүрүүд болон дотуур байрны багш нар болон сургуулийн ажилчид охидын сарын тэмдэг ирсэн үед дэмжлэг үзүүлэх эсвэл үзүүлэхгүй байхад бас чухал үүрэгтэй. ФБЯ-д оролцсон өөр өөр насны охидын хэлснээр зарим туслах ажилтнууд дэмжлэг үзүүлдэггүй байна.

- **“Шөнө 00 руу хамт очдог. Хаалга цоожилсны дараагаар, гадаа гарч шээхийг зөвшөөрдөггүй. Дотуур байрны жижүүр өвлийн цагт 17.00–18.00 цаг, харин зун цагт 19.00–20.00 цагийн үед цоожилдог. Тэгээд бие засья гэсэн ч гаргадаггүй.”(С9\_ОФБЯ\_2)**
- **“Заримдаа үйлчлэгч эгч завсарлагааны үеэр цэвэрлэгээ хийж байна гээд хүүхдүүдийг 00-д оруулдаггүй.”(УБ тайлан)**
- **“Намайг очих бүрт цоожтой байдаг. Заримдаа цоожгүй үед, үйлчлэгч эгч загнаад биднийг оруулдаггүй. “Өөр 00 руу яваа, цэвэрлэж байгааг харахгүй байна уу?”гэдэг.”(С4\_ОГЯ\_2)**

### **Тодорхойлогч хүчин зүйл 3. Сарын тэмдэг ирсэн үед яаралтай хэрэглэх материалын хүртээмж**

*Сургууль дээр хэрэгсэл худалдаж авч чаддаггүй*

Охид, ээж нар, багш нар, эрүүл мэндийн мэргэжилтнүүд гээд бүгдийн хэлснээр охид зөвхөн худалдаж авсан АЦХ хэрэглэдэг бөгөөд хааяа юу ч байхгүй үед, жишээ нь алслагдмал хөдөө газар буй үед охид гарт байгаа зүйлээ ашиглах тохиолдол байж болох талтай байдаг байна. Жишээ нь, нэг охин хөдөө байдаг эмээ дээрээ очиход эмээ нь АЦХ-ийн оронд даавуу хэрэглэ гэж зөвлөж байсан тухай ярьжээ.

**“Сургуулийн охидод эрүүл ахуйн ээлжит үзлэг хийж байхад рекламаар гарсан хэрэгслийг бүгд хэрэглэдэг гэж хэлж байсан.” (ГМЯ\_Хөдөөгийн өсвөр үеийнхний эмч)**

Сургуулийн эмч нар жилдээ гурваас доошгүй удаа сурагчдыг эрүүл мэндийн үзлэгт оруулж, шүдний үзлэг хийх, мөн, анги ба сургуулийн ариун цэврийн байдлыг хянах үүрэгтэй. Сурагчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах, мэдээлээр ханган зөвлөгөө өгөх нь энэ үүрэгт бас багтдаг. Өсвөр үеийнхэнтэй ажилладаг эмч нар охидын эрүүл ахуйтай холбоотой өвөрмөц асуудлыг онцлон дурьдаж байв.



Хот, хөдөөгийн бүх дэлгүүрт АЦХ элбэг зарагддаг. Гэсэн хэдий ч сургуулиуд дээрх АЦХ-ийн хүртээмжийн байдал ялгаатай. Хотын сургуулиуд дотор АЦХ зардаг тул охидод мөнгө байвал худалдан авахад ямар ч төвөггүй байдаг. Гэхдээ сургууль дээр зарж байгаа хэрэгсэл гадна зардгаас илүү үнэтэй байдаг гэж охид баталж байв. Ерөнхийдөө хот суурин газартай харьцуулахад хөдөө орон нутагт АЦХ арай илүү үнэтэй байдгийг тэмдэглэх нь зүйтэй. Ихэнх хөдөөний сургуулийн орчинд АЦХ зардаггүй. Хэрвээ охидод хэрэгсэл хэрэгтэй бол сургуулиас гадагшаа гарч, мөнгө нь хүрч байвал зэргэлдээ дэлгүүрээс худалдан авахаас өөр аргагүй болдог. Хэрвээ мөнгө нь дутвал, ангийнхаа хүүхдээс, түүний дотор хөвгүүдээс зээлэх эсвэл сургуулийн эмч, эмэгтэй багш эсвэл яаралтай үед тус болж болох хэнээс ч хамаагүй гуйдаг байна.

Нас нь арай бага охид нь эрэгтэй худалдагчаас эсвэл ойр орчимд нь эрэгтэй хүн байвал хэрэгсэл худалдаж авахаас ичдэг тул эмэгтэй худалдагчтай дэлгүүр лүү явах, эсвэл эрэгтэй хүмүүсийг дэлгүүрээс гарахыг нь хүлээдгээ хэлж байлаа. Эгчмэд охидын хувьд үүнд санаа зовдоггүй, ангийнхаа эрэгтэй хүүхдээс ч хэрэгсэл авах мөнгө зээлэхдээ шууд хэлдэг гэжээ.

Сургууль дээр яаралтай шаардлага гарах тохиолдолд охид АЦХ-ээ бэлэн авч явдаг, эсвэл найз нар, багш нар, эмчээсээ асуудаг байна. Ерөнхийдөө, охид АЦХ-ээ амархан унахааргүй эсвэл олохооргүй найдвартай газарт сайн нуухыг хичээдэг. Заримдаа хөвгүүд илүү үзэг, бал хайж цүнхийг нь ухаж байгаад хэрвээ хэрэгсэл байхыг харчихвал шоолж, даапаалдаг байна (хотын сургуулийн тайлан).

***“Ерөнхийдөө охидууд яаралтай үед хэрэглэх хэрэгсэл авч явдаг. Миний туршлагаас харахад охидын 80 хувь нь дэлгүүрээс, 5 хувь нь багшаасаа, 10 хувь нь найз нөхдөөсөө, тэгээд 5 хувь нь сургуулийн эмчээс авдаг.”(С10\_ ОГЯ)***

Дотуур байранд эсвэл айлд байдаг охидууд аав ээжтэйгээ ойрхон уулздаггүй тул мөнгө муутай, үүнээсээ болоод АЦХ худалдан авч чаддаггүй байж магадгүй гэж зарим нь бодлогоо охидтой хийсэн ФБЯ-ын үеэр илэрхийлж байсан. Гэхдээ энэ бол бодитоор тохиолдсон явдал гэж хэн ч хэлээгүйг тэмдэглэх нь зүйтэй юм. Энэхүү судалгаанд дотуур байрны охидыг ахлах ангийн ФБЯ-д оролцуулсан бөгөөд тэдэнд зориулсан тусгай асуулт байгаагүй тул энэ талын мэдээллийг тэд өгөөгүй. Иймээс дотуур байрны охидын нөхцөл байдлыг энэ тайланд нарийвчлан тусгах боломжгүй байсан билээ.

Түүнчлэн, айлд байдаг охидод тулгарч болох бэрхшээлийн талаар ФБЯ-д оролцсон охид ярьж байсан боловч аль нь ч өөрийгөө айлд байдаг гэж тодорхойлоогүй тул ямар нэг онцлог бэрхшээлийг нээн илрүүлэхэд хүндрэлтэй байлаа. Цус болсон хувцсаа угаах ус, газар дутагдалтайн улмаас зарим охид бусдын хувцсыг хулгайлж өмсөж байсан тухай нэг ээж ярьсан болно.

***“Дотуур байранд амьдардаг хүүхдүүд хэрэглэл (АЦХ) байхгүй, мөнгө байхгүй болохоор бие биенийхээ хувцсыг хулгайлж өмссөн тохиолдол гарсан.” (С9\_ЭэжФБЯ)***

Дотуур байрны охидууд голдуу малчин айлын хүүхдүүд тул гэр лүүгээ ойр ойрхон очих боломжгүй, иймээс тэдэнд эцэг, эхийн дэмжлэг дутдаг. Ээж нартай хийсэн ФБЯ-ын оролцогчид, дотуур байранд байгаа охидод нь АЦХ авах мөнгө хэрэгтэй байдгийг зарим эцэг, эхчүүд мэддэггүй байж магад гэж бодлогоо хуваалцсан.

#### *Охид нимгэн хэрэгсэл сонгодог*

Охидууд маш нимгэн, жижиг хэрэгслийг сонгодог нь илүү, хэрэглэхэд эвтэйхэн, хамгийн чухал нь сарын тэмдэг ирж байгааг бусад хүмүүс анзаарахгүй гэж боддогтой нь холбоотой. Гэсэн хэдий ч, хувцас нь нэвтэрч, толбо тогтох тохиолдол гарч байвал эдгээр нимгэн хэрэгсэл нь хангалттай хамгаалалт болж чадахгүй байгааг харуулж байж болох талтайг тэмдэглэх нь зүйтэй.

***“АЦХ авахдаа нимгэн, уртыг нь сонгодог... чийг татдаггүй байх хэрэгтэй. Үнэр дарагчтай байх хэрэгтэй. Сайн шингээдэг байх хэрэгтэй.” (С9\_ОФБЯ\_2)***

Бүгд биш ч зарим охид янз бүрийн хэрэгслийг өөр өөр зорилгоор хэрэглэдэгээ хэлсэн. Жишээ нь, шөнө эсвэл сургууль дээр байхдаа зузаан, урт шөнийн хэрэгсэл, харин бусад үед нимгэнийг хэрэглэдэг гэжээ.

#### *Ээж, аав нар охиндоо чанар сайтай хэрэгсэл авч өгөхийг хүсдэг*

Охидууд АЦХ-ээ голдуу гэртээ хадгалдаг. Ээж нар хэрэгтэй үед нь охиндоо хэрэгсэл авч өгөх, янз бүрийн хэрэгслийн сайн болон муу талыг тайлбарлах зэргээг практик дэмжлэг үзүүлдэг байна. Өөрийн охиндоо хэрэгсэл авч өгөхөд үнэ өртөг нь чухал хүчин зүйл биш гэж ээж нар баталж байв.

Зарим охид, аав нь ариун цэврийн хэрэгсэл авах мөнгө өгдөг, хэдийгээр энэ асуудалд өөрсдөө оролцох нь ховор ч хааяа өөрөө худалдан авч өгөх зэргээр дэмждэг талаараа мэдээлсэн.

- ***“Тэр үнэ нь чухал биш шүү дээ. Чанар чухал. Зарим хэрэгсэл харшил өгөөд байдаг. Нимгэн нь зүгээр бас тэр пампагар нь онцгүй. Тэр нэг жижигхэн ягаан нь бас онцгүй.. Хятадаас орж ирдэг гэсэн. Нэг ногоон өнгөтэй юм байнаа. Нэг их сэнгэнэсэн.. үнэр дарагчтай гэнэ үү”.***
- ***“Тэр жижиг нарийхан яагаав. Тэр чинь өдөр тутам.”(С9\_ЭэжФБЯ)***
- ***“Тэгсэн харин би ноднин мэддэггүй. Энэ нэг жижиг юмыг яаж хэрэглэдэг юм бол гэж бодоод байсан чинь манай охин “Ээжээ энэ их аятайхан, авч хэрэглээч гэж байна лээ”.(С9\_ЭэжФБЯ)***
- ***“Манай нөхөр надад “Охиндоо хамгийн чанартай хэрэгслийг нь авч өгөөрэй, намайг авч өгөхөөр ичих байх” гэж зөвлөсөн.” (С10\_БагшФБЯ)***

#### **Тодорхойлогч хүчин зүйл 4: Нийгэм –сэтгэл зүйн дэмжлэгт орчин**

##### *Ариун цэврийн өрөө ашиглах сургуулийн журам*

Сурагчдыг хүссэн үедээ ариун цэврийн өрөө ашиглахыг зөвшөөрсөн дүрэм бүх бүх сургуульд байдаггүй.

Хичээл хоорондын завсарлагааны таван минут нь нэг ангиас нөгөө анги руугаа очиж ороход л хангалттай, харин бие засахад хангалтгүй хугацаа юм. Өдрийн их завсарлагааны 10-15 минутаар бие засах өрөө дүүрэн хүүхэдтэй эсвэл жорлон нь сургуулийн барилгаас зайтай байх тул эмэгтэй сурагчид тэр бүр бие засах эсвэл хэрэгслээ сольж чаддаггүй байна.

- ***"Завсарлагааны цагаар 00-д орж амждаггүй. Хөвгүүд, охидод зөвхөн нэг нэг, багш нарт нэг дотроо 00-той болохоор завсарлагааны цаг хангалтгүй. Дотроо хоёр суултууртай охидын 00 гадаа байдаг ч бас л хангалтгүй."*** (С6\_ОФБЯ)
- ***"Энэ нь сургуулийн барилгаас нэлээд зайтай. Гүйгээд очсон ч урт оочертой байдаг болохоор амждаггүй."***(С11\_ОФБЯ\_1)

Зарим сургууль их завсарлагааны 10-15 минутаар бүх сурагчдаар дасгал хийлгэдэг тул ариун цэврийн өрөө орох цаг бага болдог байна.

- ***"Гурвын завсарлагаанаар л гарахаас биш зарим багш нар нь гаргана. Зарим багш нар нь гаргахгүй."*** (С9\_ОФБЯ\_1).
- ***"Ангийн багш биений юмны талаар яриа хийдэггүй. Учир нь манай анги эрэгтэй багштай шүү дээ (инээлдэв)".***(С9\_ОФБЯ\_2)

Гүйх, харайх зэрэг биеийн дасгалын үеэр цус доошоо ихээр гарч, хувцас нэвтэрч, толбо тогтдог гэдэгт итгэдэг гэж охид тайлбарлаж байв. Иймээс биеийн тамирын хичээлд орохгүйг хичээн янз бүрийн шалтгаан хэлэх, тэр байтугай хэрвээ багш нь эрэгтэй байвал худлаа хэлдэг байна.

Зарим сургуульд бие засах өрөө байгаа ч ээлжилж онгойлгодог, эсвэл хичээлийн цагаар онгойлгодог, хичээл дуусангуут түгждэг нь ажиглагдсан. Энэ нь магадгүй үйлчлүүлэгчийн ачааллыг багасгах эсвэл засвар үйлчилгээнд гарах санхүү, хүн хүчний зардлыг хэмнэхэд хэрэгтэй байдаг байж мэдэх юм.

- ***"Зөвхөн гурвын засварлагаа 10 минут үргэлжилдэг учраас хүүхдүүд зөндөө их, бүүр аймаар оочерлочихдог болохоор сургууль дээр ариун цэврийн хэрэгсэл солих боломжгүй."*** (С9\_ОФБЯ\_1)
- ***"Тэгээд хүлээх гэхээр завсарлагаа дуусчихна. Тэгээд хичээлдээ орохгүй болохоор хаачаад ирэв гээд (багш) уурлана ш дээ."*** (С9\_ОФБЯ\_1)
- ***"Сургуулийн 00 хичээлийн цагаар хаалттай, зөвхөн завсарлагааны цагаар онгорхой байдаг."*** (С8\_ОФБЯ\_1)

*Гэр бүл, дотуур байр ба сургуулийн дэмжлэг*

Ихэнх охид гэр бүлийнхээ эмэгтэй гишүүдээс, заримдаа ааваасаа дэмжлэг авдгаа баталж байсан билээ. Үүнд мэдээлэл, АЦХ авах, ус зөөх гэх мэт гэрийн хүнд хүчир ажил хийхээс чөлөөлөгдөх зэрэг багтдаг байна. Гэвч дотуур байранд эсвэл айлд байгаа охидод дэмжлэг бага байдаг. Хэдий ийм боловч, сарын тэмдэг ирсэн үед охидод бэрхшээл тулгарсан хэвээр байгаа гэж охид үздэгийг тэмдэглэх нь зүйтэй юм.

***“Хотын захын сургуулийн сурагчдын 45-аас илүү хувь нь орлого багатай айл өрхийн, уурхайн ажилчдын хүүхдүүд байдаг... зарим эцэг эх охиддоо ариун цэврийн хэрэгсэл авч өгч чаддаггүй. Тийм айлын охидууд дуугай, өөртөө итгэлгүй, сул дорой байдаг.”(СЗ\_сургуулийн захирал\_тайлан )***

Өнөө цагт хүүхдүүд өмнөх үеийнхэнтэй харьцуулахад илүү нээлттэй болж байгаа ч олон охид сарын тэмдэгтэй холбоотой асуудлын талаар аав, ах нартайгаа ярьж чадахгүй хэвээр байна.

Дотуур байрны охидын хувьд сэтгэл санааны болон материаллаг дэмжлэгийг ангийн найз нөхөд, байрны багш нараасаа авч байна. Гэлээ ч, эцэг эхээсээ хол амьдарч байгаа тэд бэлэн мөнгөөр дутагддаг, ариун цэврийн хэрэгсэл худалдан авахад хүндрэлтэй байдаг бол, айлд байгаа охидод ч энэ байдал нь ижил юм. Ийм тохиолдолд охидууд найз нараасаа мөнгө эсвэл хэрэгсэл зээлдэг байна.

### **Тодорхойлогч хүчин зүйл 5: Биологийн хүчин зүйлс**

Биологийн хүчин зүйлст сарын тэмдэг анх ирэх нас, давтамж болон өвдөлтийн шинж тэмдгүүд багтдаг. Судлаачидтай хуваалцсан охидын түүхээс харахад сарын тэмдэг анх ирсэн нас 9-14-ийн хооронд хэлбэлзэж байна. Насаар бага охид сарын тэмдгийн талаар бүрэн дүүрэн ойлгож мэдээгүй, өөртөө анхаарал тавих талаар дөнгөж сурч эхэлж байгаа тул илүү эмзэг байдаг байна. Анхны сарын тэмдгийн талаарх охидын бичсэн түүхээс үзэхэд бүгд л айж, хямарч, цочирдсон талаар өгүүлсэн байлаа.

Мөчлөг тогтворгүй байдаг нь цус гоожих, хувцас нэвтрэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн нэг болдог байна. Ялангуяа эхний үедээ охидын сарын тэмдгийн мөчлөг тогтмол бус, хэмжээ нь харилцан адилгүй байдаг байна. Энэ насны охид хэдийд сарын тэмдэг нь ирэхийг мэддэггүй тул сургуульдаа бэлтгэлгүй явдаг бол эгчмэд охид сарын тэмдгээ ирэх дөхсөн үед цүнхэндээ АЦХ-ээ авч явдаг гэжээ. Охидууд 10-14 насны хооронд тэдний сарын тэмдэг ирж байсан гэж хэлсэн, гэтэл ихэнх ээж, багш нар 13-15 насны хооронд буюу арай хожуу ирэх байх гэсэн хүлээлттэй байдаг байна.

***“ Сүүлийн үед залуужихсан. Бага байхад нь ирж байна [биеийн юм] Манай хүүхдийнх 14 наснаас...Бид нарын үед чинь 17,18 хүрч байхад ирдэг байсан..”  
(С9\_ЭэжФБЯ)***

Ерөнхийдөө, хот, хөдөөгийн охидын биеийн хөгжил, ялангуяа биеийн өндөр ялгаатай байна. Хөдөө нутгийн, ялангуяа сумын сургуулийн охид үе тэнгийн хотын охидоос намхан байх хандлага харагдаж байна. Иймээс өсвөр насны хүүхдүүдийн өсөлт, түүний хурдцын талаарх тоо баримт, мэдээллийг хот ба хөдөөгийн бүлгээр салган ялгах, цаашид энэ асуудлыг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.

Ээж нарын хувьд сарын тэмдгийн эрүүл ахуйн талаар багш нь зөвлөх байх гэж боддог бол багш нар харин ээж нар хийх ёстой гэж боддог байна. Зарим нь АЦХ -ийн талаар охин нь сургуулиасаа эсвэл өөр газраас аль хэдийнэ олж мэдсэн гэж боддог тул энэ талаар зааж өгдөггүй байна.



## Боловсрол ба эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, эрсдэл

Сарын тэмдэг ирсэн үед охидод учирч буй бэрхшээлүүд нь тэдний эрүүл мэнд болон боловсролд нөлөөлж, эрсдэлд оруулж болох талтай. "Оролцогчдын дурдсан үр нөлөө" гэсэн хэсэгт охидын эрүүл мэнд, хичээл боловсролд нь болон зан үйлд нь сөрөг нөлөө үзүүлж байгаа гэж охид ээж нар болон багш нарын үзэж буй зүйлийг ярилцлагын үеэр илэрхийлснийг тэдний өөрсдийнх нь үгээр тусгасан байгаа.

### Оролцогчдын дурдсан үр нөлөө

*Оролцогчдын дурдсан үр нөлөө 1. Сарын тэмдэг ирэх үед биед илрэх шинж тэмдэг*

Сарын тэмдэг ирэх үеэр хэвлийн доод хэсгээр базлах, нуруу өвдөх, ерөнхийдөө бие сулрах, ажил хийх сонирхолгүй болох зэрэг зарим шинж тэмдэг охидод тулгардаг байна. Тэдний бие тавгүйрхэж, орны даавуугаа цус болгох, хувцас нэвтрэхээс санаа зовон сайн унтаж чаддаггүй тул дараагийн өдрийн хичээл дээр их ядардаг гэжээ.

**"Охидууд санаа зовно, бүр шөнөдөө тайван унтаж ч чаддаггүй. Нэвтэрчихээс нь айгаад хажуу талаараа харж унтахад хүрдэг.(С4\_ОФБЯ\_2)**

*Оролцогчдын дурдсан үр нөлөө 2. Хичээлээс, ялангуяа биеийн тамирын хичээлээс чөлөө авах*

Сарын тэмдэг ирсэн үед охид хичээл дундуур ариун цэврийн өрөө орохоор байнга чөлөө авч гарч явдаг, ялангуяа биеийн тамирын хичээл тасалдаг талаар охид, багш нар хэлж байв. Охидын өгүүлснээр биеийн тамирын хичээл дээр гүйж, харайх эсвэл дасгал хийвэл цус их гарна гэж айдаг тул хичээлд оролцоход их хэцүү байдгаа хэлж байв. Түүнээс гадна, сарын тэмдэг ирсэн үеэр гүйж болохгүй гэж тэдэнд зөвлөсөн байдаг байна.

Хэрвээ биеийн тамирын багш нь эрэгтэй бол охид ичээд хичээлээс чөлөө авч чаддаггүй гэжээ.

- **"Охидууд сард нэг удаа биеийн тамирын хичээл тасалдаг."(С10\_БагшФБЯ)**
- **"Хэрвээ хичээлийн дундуур хэрэгслээ (ариун цэврийн) солихоор бол би багшаас чөлөө аваад гэр лүүгээ явдаг." (Хотын сургуулийн тайлан)**
- **"Заримдаа АЦХ-ээ солихын тулд худлаа хэлж чөлөө авна... гэрээс дуудаж байна гэдэг ч юмуу.."(С9\_ОФБЯ\_2)**

Охид үе үе хичээл дундуур гардаг, заримдаа хэрэгслээ солихын тулд ариун цэврийн өрөө орох эсвэл хэвлийгээр базалж өвдсөн үед худлаа хэлэхэд хүрдэг.

*Оролцогчдын дурдсан үр нөлөө 3. Анхаарал төвлөрөлт болон ангийн үйл ажиллагаанд оролцох оролцоо нь буурах*

Сарын тэмдэг ирж байх үеэр охидууд ангиас зохиож буй үйл ажиллагаанд оролцох, мөн анхаарлаа төвлөрүүлэх байдал нь суларч ирдэг байна. Самбарын өмнө зогсож багшийн асуултанд хариулах дургүй байдаг нь хамаагүй хөдөлснөөс хувцас нь нэвтэрч эсвэл толбо

тогтсон байх нь харагдчих байх гэдгээс айдаг гэжээ. Ийм зүйлст санаа зовсноос, ангид юу болж байгаад анхаарал тавихад тэдэнд хүндрэлтэй байдаг байна.

- **[төсөөлж буй охины тухай] “Өмдөндөө анхаарсаар байгаад таарна. Энэ охин чөлөө авч чадахгүй болохоор тасалж (хичээлээ) бас чадахгүй тэгээд суугаад өнжинө. Тэр хүүхдийн анхаарал төвлөрөх чадвар нь муудна.” (C9\_ОФБЯ\_1;C9\_ОФБЯ\_2)**
- **“... охин ангийн хойно сууна.” (C9\_Эрүүл мэндийн багш )**
- **“...хичээлээр зааж байгаа зүйлд анхаарч чаддаггүй.”(C11\_ОФБЯ\_2)**
- **“Нэвтэрчихсэн байх вий гэж санаа зовдог болохоор би байнга босч сандал дээр цус дуссан байна уу гэж хардаг.”(C2\_ОФБЯ)**
- **“Хичээл орж байхад АЦХ авч явахаа мартчихсан. Тэгээд яг ингээд л 7 цаг ордог байхгүй юу. Сүүлийн цаг дээр нэвтрэх гээд байгаа юм шиг санагдаад байсан. Тэгээд бүүр сүүлдээ санаа зовоод сандал дээрээсээ байн байн босоод тэгээд алхаад ирж байхдаа доошоогоо нэвтэрчихвий дээ гээд гэртээ харьтал битгий гоожчихоосой гэж бодож байсан тэр үед аймаар санаа зовж байсан. Тэр үе л аймаар том дурсамж болж байсан.” (C2\_ОГГЯ)**

Оролцогчдын дурдсан үр нөлөө 4. Шээсээ барих

**“Охидын 00-ийн хүртээмж муу, орой 18:00 цагаас цоожилдог болохоор хөвгүүдийн 00-д орохоос өөр аргагүй болдог. Тэгж байхдаа (эмэгтэй хүүхэд 00 хэрэглэх) эрэгтэй хүүхэдтэй таарч ичиж, айсан тохиолдол гардаг.” (C1\_ОФБЯ\_2)**

Хичээл голдуу өглөөний 8 цагаас оройн 7 цаг хүртэл үргэлжилдэг. Гэхдээ үйлчлэгч нарын ажил 17 цагт дуусдаг тул цэвэрлэсэн ариун цэврийн өрөөгөө цоожлоод явдаг байна. Иймээс сургуулиас гадуур үйл ажиллагаанд оролцдог сурагчид маргааш өглөө хүртэл ариун цэврийн өрөөнд орох боломжгүй болдог. Энэ байдал, дотроо усан татуургатай жорлонтой хотын сургуульд олонтаа тохиолддог. Заримдаа хичээлийн болон хичээлийн бус цагаар нийт ариун цэврийн өрөөний хагас нь нэг бол хөвгүүдийн эсвэл охидынх хаалттай байдаг.

**“Дотуур байрны (хөдөөний) хүүхдүүд өвөл эсвэл шөнийн цагт хүүхэдтэй (гадаа жорлонтой тул) цуг гараад л бие засна эсвэл жижүүртэйгээ гараад (хамт) гараад бие засна. Найзтайгаа цуг гараад бие засна.” (ХөдөөC9\_ОхидФБХ\_2)**

Эдгээр нөхцлийн улмаас охидууд бохир заваан бөгөөд хүйтэн бие засах газрыг ашиглахаас зайлсхийн шээсээ аль болох барьдаг гэжээ. Гэхдээ, ариун цэврийн өрөөний нөхцөл байдал хангалттай сайн биш учраас сургуулийн жорлонд орж бие засахаас зайлсхийх байдал нь хөвгүүд, охидын аль алиных нь дунд түгээмэл байсан гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

*Сарын тэмдэг ирэхийн өмнө ба ирсний дараа охидод гарах өөрчлөлт*

ФБЯ-д оролцсон охидууд сарын тэмдэг анх ирсний дараах гарсан өөрчлөлтийн талаарх туршлагаа ярилцсан. Тэднийг дотор нь хоёр бүлэгт хувааж, хэсэг зуур хоорондоо ярилцаад “ердийн нэг охин” төсөөлж сарын тэмдэг ирэхийн өмнө ба ирсний дараа гарсан өөрчлөлтийг нь зурах эсвэл жагсаалт гарган бичихийг хүссэн (Зураг 18 ба 19 харар).

**Сарын тэмдэг анх ирэхээс өмнө ба дараа охидод гарсан өөрчлөлт**


*Сарын тэмдэг анх ирэхийн өмнө:*

Аз жаргалтай, нөхөрсөг, нээлттэй. Идэвхтэй, гүйж харайсан, спортоор хичээллэдэг. Гэр бүлийнхэнтэйгээ аялах, хамаатныдаа айлчлах дуртай, гэрээсээ хол байж чаддаг. Дуртай хувцсаа өмсөж болдог. Анзааргагүй, юунд ч санаа зовдоггүй, шулуун. Хөвгүүдтэй тоглодог. Өөртөө санаа тавьдаггүй

*Сарын тэмдэг ирсний дараа:*

Сэтгэл түгшдэг, тавгүй, анхаарал төвлөрөх нь муу, анхаарал нь зөвхөн биеийн юманд чиглэсэн. Санаа зовомтгой, уцаартай, ичимхий, ганцаардсан, дуугаа хураах. Хөвгүүдтэй харилцахаас зайлсхийдэг, ангийнхаа хамгийн арын ширээнд суух дуртай болох. Гэнэт огцом хөдөлгөөн хийх, үсрэх эсвэл найзуудтайгаа бүжиглэх дургүй болох. Биеийн юм ирэх үеэр нуруу, хэвлийгээр өвдөх. Аялалаар явах эсвэл гэрээсээ хол амралтын газар, хамаатныдаа хонох дургүй болох. Юу өмсөх, яаж харагдаж байгаагаа анхаарч эхлэх. Бараан хувцас, юбканаас илүүтэй өмд өмсөхийг илүүд үзэх. Гадна төрх байдал, биеэ авч явах байдал, бусадтай ярилцахдаа, ялангуяа хөвгүүдтэй, илүү анхаарах. Бусад охидтойгоо илүү нээлттэй болж, туршлагаа хуваалцах. Цэвэрхэн байх, эрүүл ахуйдаа илүү санаа тавих, хувцсаа илүү ойр ойрхон угаадаг

Зураг 18, 19. Сарын тэмдэг анх ирэхээс өмнө ба дараа



Эх үүсвэр: С6\_ОхидФБХ\_1

**Болзошгүй эрсдэлүүд, эрүүл мэндийн үзүүлэх сөрөг нөлөө**

*Эрсдэл 1. Сурлага болон спортын амжилт буурах*

Сарын тэмдэг ирсэн үед охидын анхаарал сул байдаг нь хичээлийн агуулгаа ойлголгүй өнгөрнө гэсэн үг юм. Энэ нь шалгалтанд сөрөг нөлөөлж болох талтай ба сурлагын амжилт муудахад хүргэж болох юм.

Үүнтэй адилаар, сарын тэмдэг ирсэн үед хөдөлгөөнөө хязгаарлан, байн байн биеийн тамирын хичээлд орохгүй байх нь тэдний спортын амжилтыг бууруулж болно.

*Эрсдэл 2. Сургуулиас гарах*

Хөвгүүдийн зүгээс сарын тэмдэг ирсэн үед охидыг байнга шоолж элэглэх нь охидыг ихээхэн эвгүй байдалд оруулж, ичиж зовоход хүргэж байгаа нь магадгүй тэднийг сургуулиа орхиход хүргэж болох эрсдэлтэй.

**“... Хувцас нь нэвтэрчихсэн (цус) нэг охиныг хөвгүүд шоолсноос болоод тэр охин сургуулиа солихоос өөр аргагүйд хүрч байсан.” (АймагС10\_ОФБХ\_2)**

Сургуулийн орчинд хөвгүүдэд шоолуулах, доромжлуулах нь томоохон асуудал байдаг тул охид сарын тэмдэг ирснийг нь, эсвэл ариун цэврийн хэрэгсэл авч явааг нь хөвгүүд ажиглачих вий гэж охид их айдаг. Гэтэл, эрэгтэй багш нар энэ асуудлын талаар хөвгүүд эсвэл охидуудтай ярилцах хангалттай мэдлэггүй эсвэл ярилцах ур чадвар муутай байдгаас хөвгүүдэд шоолуулж буй охидод дэмжлэг үзүүлэх, хөвгүүдийн шоолохыг зогсоох талаар санаа тавьдаггүй. Харамсалтай нь хэрвээ хөвгүүд, сарын тэмдэг ирсэн үеэр, ер нь бусад ямарч үед ч шоолж дооглож болохгүй гэдгийг ойлгохгүй бол цаашдаа энэ зан үйл даамжирч, улмаар охид суралцах дургүй болж, сургуулиа хаях, өөрийгөө хүндэтгэх болон өөртөө итгэх итгэлээ алдах, магадгүй сэтгэцийн асуудалтай ч болж болох юм.

Хөвгүүдтэй хийсэн ФБЯ-ын үеэр сарын тэмдэг ирэх үеийг төсөөлсөн дасгалын үеэр нэг хөвгүүн “Охидыг шоолж байсандаа ичиж байна. Одоо тэднийг өрөвдөж байна” гэжээ (хотын захын сургууль, туршилтын үеэр). Энэ нь хөвгүүдэд энэ байдлыг илүү сайн ойлгуулах нь чухал гэдгийг харуулж байна.

### Эрсдэл 3: Охидын биеийн болон сэтгэл санааны байдалд гарах сөрөг үр нөдөө


Сарын тэмдэг ирснээ нуух, ойр дотныхоо хүмүүст чөлөөтэй ярилцаж чадахгүй байх, байнга хямралтай байх, айх, үргэлж санаа зовсон байдалтай байх нь охидын биеийн болон сэтгэл санааны сайн сайхан байдалд нөлөөлж болох талтай.

Ихэнх охид, сарын тэмдэг ирж байх үедээ эвгүй үнэр гарах, нэвтрэх болон толбо тогтох, мөн бусад хүмүүс анзаарахаас айдаг тул өөрийгөө бусдаас тусгаарладаг байна. Энэ нь тэдний өөрийгөө хүндлэх, өөртөө итгэлтэй байхад нөлөөлж, улмаар ганцаардаж, тусгаарлагдсан бөгөөд бусадтай нийлдэггүй болгоход хүргэж болох юм. Түүнээс гадна тохиромжгүй, эрүүл ахуйн нөхцөл хангаагүй ариун цэврийн өрөө нь сурагчдын, ялангуяа охидын дунд халдвар тараах нөхцөл бүрдүүлж болох билээ.

Өмнө дурьдсанаар, олон охид шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжийг ашиглахаас зайлсхийж, гэртээ харьтлаа олон цагаар шээсээ барьж байна. Энэ нь охидын эрүүл мэндэд, тухайлбал шээс дамжуулах замын үрэвсэл үүсэхэд хүргэж болох талтай.

## Гол үр дүнгийн нэгдсэн дүгнэлт

Сарын тэмдэг ирсэн үед охидод тулгарч буй нийгэм-экологийн өөр өөр түвшний хүндрэл бэрхшээлийг зураг 20 дээр бүлэглэн үзүүлээ.



Зураг 20. Нийгэм-экологийн ялгаатай түвшнүүд



**Нийгмийн түвшин:** Засгийн газраас сургуулийн орчинд УАЦЭА-н байгууламжийг сайжруулж, хүүхдэд ээлтэй орчинд суралцан, өөрсдийнхөө дээд хэмжээгээр суралцах бололцоог бүрдүүлэхэд асар их хүчин чармайлт гаргасан билээ. Хамгийн тод жишээ бол 2015 онд “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага”-ыг гурван гол яамдын (БСШУЯ, ЭМСЯ, СЯ) идэвхтэй дэмжлэгтэйгээр баталсан. Эдгээр норм, шаардлагыг үндэсний болон орон нутгийн төрийн бүх удирдлагууд хэрэгжүүлэх ажлыг эхэлсэн бөгөөд зарим аймгийн, дүүргийн засаг захиргаанаас сургуулийн орчинд УАЦЭА-н байгууламжийг сайжруулахад улсын, орон нутгийн хөгжлийн төсвөөс хуваарилалт хийж эхэлж байна. Гэсэн хэдий ч бүх газарт сургуулийн УАЦЭА-н байгууламжийн талаар сэтгэл гаргахгүй, хариуцсан агентлаг болон орон нутгийн засаг захиргаа нь энэхүү нэн чухал салбарт хөрөнгө хуваарилахгүй байгаа нь харагдаж байна. Түүнчлэн, хуваарилсан төсөв нь хэрэгцээтэй харьцуулахад хэт бага байх нь түгээмэл байна.

Хүмүүсийн хандлага болон зан үйлд сарын тэмдгийн талаар ил ярьдаггүй, хаалттай сэдэв хэмээн ойлгодог сэтгэлгээ нөлөөлж байна. Эцэг, эхчүүд, багш нар, нутгийн хүмүүс болон сургуулийн охид өөрсдөө хүртэл сарын тэмдэгтэй холбоотой бүхнийг бусдаас, ялангуяа эрэгтэй хүмүүс, хөвгүүдээс, нуухыг дээд зэргээр хичээдэг байна. Хөвгүүд хэрвээ охидын сарын тэмдэг ирж байгааг мэдчихвэл тэднийг шоолж даажигнадаг байна.

**Хүрээлэн орчны түвшин:** Бүх сургуулийн УАЦЭА-н байгууламжууд нь сарын тэмдгийн эрүүл ахуйг сахихад охидын хувийн нууцлалыг хангасан, тавлаг, айх айдас ичих зүйлгүй орчинд зохицуулах охидын хэрэгцээ шаардлагад тэр бүр нийцэхгүй байна. Ялангуяа, хөдөөний сургуулиудын УАЦЭА-н байгууламжийг дэд бүтцийн хувьд сайжруулах, урт хугацаанд хэрэглэхээр засварлах хэрэгцээ байсаар байна.

**Хүмүүс хоорондын түвшин:** Охидууд сарын тэмдгийн тухай мэдлэг, хэрхэн зохицуулах чадвар муутай байгаагаас байнга стресстэй байх, бусдаас өөрийгөө тусгаарлах, хамгийн арын ширээнд суух, бусад сурагчдын хамтаар сургуулиас зохиож буй үйл ажиллагаанд идэвхтэй оролцохгүй байх, цус ихээр гарах байх гэж айснаас хөдөлгөөнөө хязгаарлахыг хичээх байдалд ордог байна. Түүнчлэн бусдаас, ялангуяа хөвгүүд биеийн юм ирж байгааг нь анзаарахаас хамгаалж, зөвхөн ээжтэйгээ эсвэл хамгийн дотны найз нараас өөр хүнтэй энэ талаар ярилцдаггүй байна. Сарын тэмдгийн талаар эрэгтэй хүмүүсээс таг нуух хэрэгтэй гэсэн ойлголт түгээмэл, энэ ойлголт охидын дунд маш хүчтэй байна.

**Хувь хүний түвшин:** Нас бага охидын хувьд сарын тэмдгийн талаарх мэдлэг тааруу, хэрхэн зохицуулах талаар маш бага ойлголттой тул ээж, эгч нарынхаа зөвлөгөөг голдуу дагадаг байна. Охидууд ариун цэврийн хэрэгслийн чанарын тухай мэдлэг муутай, орныхоо даавуу эсвэл хувцсаа цус болгохоос айж нойр муутай хонох зэргээр сарын тэмдгээ зохицуулахад санаа зовж, түргэн ууртай болдог байна. Ихэнх охидод, сарын тэмдэг анх ирэхээс өмнө илүү аз жаргалтай, зоригтой, илүү идэвхтэй байсан гэж санагддаг байна.

**Биологийн түвшин:** Сарын тэмдэг ирсэн үед, охидод нуруугаар өвдөх, хэвлийн доод хэсгээр базлах, заримдаа толгой эргэх, ядрах байдал илэрдэг бөгөөд ихэнх нь эдгээр шинж тэмдгийг хэрхэн зохицуулах талаар мэддэггүй гэжээ. Зарим нь эм уудаг боловч, дийлэнх нь өөр зүйлд анхаарлаа хандуулах эсвэл бариу дотуур өмд өмсөн өвдөлтөө багасгадаг байна. Мөчлөг тогтворгүй байх, ялангуяа бага насны охидод нэлээд хүндрэлтэй асуудал болдог байна.



## ЗӨВЛӨМЖ

### 1. ОРОЛЦОГЧДООС ГАРСАН ЗӨВЛӨМЖ<sup>17</sup>

#### УАЦЭА-н байгууламжтай холбоотой:

- Сургуулийн болон дотуур байрны давхар бүрт боломжийн хэрээр олон тооны жорлон байршуулах чухал хэрэгцээ байна. Эдгээр нь цоожтой, гэрэлтүүлэг сайтай, толь, гэр хатаагч, гар угаах саван, ариун цэврийн цаас болон хогийн савтай байх нь зүйтэй. Түүнчлэн, бие засах өрөөнд АЦХ хадгалах шүүгээ байрлуулах нь сайн юм.
- Гар угаалтуур нь жорлонгийн ойр буюу сурагчдад бие зассаныхаа дараа шууд гараа угаах боломжтой байрлалд байх нь зүйтэй.
- Сургууль яаралтай тохиолдолд ашиглах толь, сандал, тавиур, илүү юбка бүхий тусдаа булан эсвэл өрөө байвал охид бохирдсон хувцсаа сольж, угааж, ингэснээр сарын тэмдэг ирэх үеийн зарим стрессээ тайлахад нь үнэхээр хэрэгтэй юм.
- Жорлонг цэвэрхэн байлгаж, засвар үйлчилгээг шаардлагатай үед нь тогтмол хийж байх нь зүйтэй.

#### Сурагчдын оролцоо:

- Сургуулийн захиргаанаас УАЦЭА-тай холбоотой үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт болон хяналтыг сургуулийн хэмжээнд кампанит ажил явуулах, мөн л сурагчийн өөрийн удирдлагын байгууллагуудаар дамжуулан явуулахыг дэмжин ажиллах нь зүйтэй.

#### Мэдлэг, мэдээлэл:

- Охидод тулгардаг бэрхшээлийн талаарх багш нарын, ялангуяа эрэгтэй багш нарын мэдлэг болон ойлголтыг сайжруулах тусгай сургалт явуулах нь зүйтэй.
- Эрэгтэй багш нар сарын тэмдэгтэй холбоотой асуудлуудын талаар хөвгүүдэд заах, мэдээллээ хуваалцах болон ярилцах зэргээр тэдэнд үлгэр дууриал үзүүлж болох юм. Энэ нь охидыг ойлгох, тэднийг шоолж дооглохоо болиход нь хөвгүүдэд нөлөөлж болох юм.
- Сургуулиас багш нар, эцэг эхчүүд, хөвгүүд болон охидод чиглэсэн сарын тэмдгийн арчилгааны талаарх ойлголт бий болгох кампанит ажлыг төлөвлөж, хэрэгжүүлж болно.
- Цаашид хийх чухал алхамд сарын тэмдгийн арчилгааны эерэг туршлага ба охидод сарын тэмдгийн эрүүл ахуйг сахихад нь дэмжлэг болох зурагт хуудас, сонин, онлайн сургалтын эсвэл видео клип зэрэг мэдээллийн материал боловсруулж, орон нутгийн иргэд, эцэг эхчүүд, сургуулийн эмч нар болон боловсролын салбарын ажилтнуудад тараах ажлууд орж болох юм.
- Хөдөөгийн сургуулиудын сурагчид интернетэд холбогдон, өргөнөөр ашиглаж байгаа тул сарын тэмдэгтэй холбоотой мэдээллийг боловсруулж, энэ сувгаар цацаж болно.

<sup>17</sup> Хавсралт 6 харах.

**Ариун цэврийн хэрэгслийн хүртээмж:**

- АЦХ-ийн хүртээмжийг сайжруулахын тулд сургууль дээр зардаг эсвэл сургуулийн дотоод төсвийг зохицуулан яаралтай үед хэрэглэх АЦХ-ийг хангах механизм бий болгох.

**Сургуулийн эмч нар болон дотуур байрны багш нарын үүрэг, хариуцлага:**

- Сургуулийн эмч нар нь стандартын шаардлагад нийцсэн УАЦЭА-н байгууламжийг сайжруулах, сургуулийн багш, ажилтнууд (ялангуяа эрэгтэй багш нар) хөвгүүдийн ойлголтыг бэхжүүлэх, мэдээлэл харилцааны материал боловсруулах болон зөвлөгөө үзүүлэх үйлчилгээгээр хангах зэрэгт идэвхтэй оролцох хэрэгтэй.

**2. СУДЛААЧДААС ГАРСАН ЗӨВЛӨМЖ****Үндэсний түвшинд:**

- Засгийн газраас цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлагыг бусад хөгжлийн хөтөлбөрийн хамтаар хэрэгжүүлэхийн төлөө бүхий л боломжийг дайчлан ач холбогдол өгч ажиллах нь чухал юм. УАЦЭА-н байгууламжууд нь охидын нэр төрийг хүндэтгэх болон тэдний боловсролын амжилтанд ихээхэн нөлөөтэй хүний үндсэн хэрэгцээ юм.
- Ирэх жилүүдэд анхаарах хөгжлийн гол асуудал нь ялангуяа сургууль, дотуур байр, цэцэрлэгийн УАЦЭА-н байгууламжуудыг сайжруулах хэрэгцээг эн тэргүүнд тавьж чухалчлан үзэх ухамсрыг шийдвэр гаргагчид, засгийн газрын болон ТББ-ын төлөвлөлтийн ажилтнууд төдийгүй нийт хүн амын дунд сайжруулах кампанит ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулахад чиглэж болно. Энэ нь Монгол орны хөгжил ба ирээдүйд амин чухал бие бялдар болон сэтгэцийн хувьд эрүүл саруул хүүхдүүдийг өсгөхөд чухал ач холбогдолтой юм.
- Сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулгад нухацтай дүн шинжилгээ хийж, шинэ агуулгыг боловсруулах, үүнд сургуулийн сурагчдын бодит хэрэгцээ, ялангуяа охидын өвөрмөц хэрэгцээ болох сарын тэмдгийн эрүүл ахуй болон эрүүл зан үйл, эрүүл хооллолт болон эрүүл саруул амьдрах зарчмууд зэрэг асуудлыг тусгасан агуулгыг сургалтын хөтөлбөрийн (албан ба албан бус) салшгүй хэсэг болгон танилцуулах нь зүйтэй.
- Эрүүл мэндийн багш, сургуулийн эмч нарыг эрүүл мэндийн хичээлийн сургалтын хөтөлбөрийн шинэ агуулга болон сурагчдад эрүүл мэндийн зөв мэдээлэл өгөх талаар сургах бас дахин сургах хэрэгтэй.
- Багш нар, эцэг эхчүүд, олон нийтэд зориулсан сарын тэмдгийн эрүүл ахуйн талаарх ойлголтыг сайжруулах мэдээллийг боловсруулах, тараахад дээд зэргээр хүчин чармайлт гаргах нь чухал ач холбогдолтой байна. Интернэт нь төрийн албан хаагчаас сургуулийн охид, хөвгүүд, багш нар болон эцэг эхчүүд зэрэг энгийн иргэдэд тэгш мэдээлэл тараах, мэдлэг хуваалцах илүү боломжийн хэрэгсэл байж болох талтай.
- Сургуулийн УАЦЭА-н гол үзүүлэлтүүдийг Боловсролын салбарын удирдлага мэдээллийн системийн (БСУМС) мэдээллийн системд оруулж, үндэсний, аймаг /дүүргийн болон орон

нутгийн түвшинд сургуулийн УАЦЭА-н байгууламжийг сайжруулах ажилд гарсан ахицыг тогтмол хянаж байх нь зүйтэй. Эдгээр үзүүлэлтийг Тэргүүний сургууль шалгаруулах гол шалгуур үзүүлэлт болгож болох юм.

- Сургуулийн удирдлага, түүний дотор сургуулийн захирлын албан тушаалд, эмэгтэйчүүдийг илүүтэй томилон ажиллуулах нь зүйтэй. Судлаачдын ажиглалтаар, эмэгтэй захиралтай сургуулийн УАЦЭА-н байгууламжуудыг нөхцөл байдал, завсар үйлчилгээ нь эрэгтэй захиралтай сургуулиудаас илүү сайн байжээ. Ихэнх багш нар нь эмэгтэй боловч захирлуудын ихэнх нь эрэгтэй байдаг Монгол Улсын хувьд энэ нь ямар нэг хүндрэл үүсгэхгүй байх гэж найдаж байна.

#### **Аймаг, дүүргийн түвшинд:**

- Аймаг болоод сумын засаг даргын газраас цэцэрлэг, дотуур байр болон сургуулийн УАЦЭА-н байгууламжуудыг сайжруулахад тэргүүлэх ач холбогдол өгч, “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага”-д нийцсэн УАЦЭА-н байгууламжийн загвар бий болгоход бүхий л хүчин чармайлтаа гаргах хэрэгтэй.
- Аймаг болоод сумын удирдлагууд, иргэдийн төлөөлөгчийн хурлын гишүүд нь цэцэрлэг, дотуур байр болон сургуулийн УАЦЭА-н байгууламжуудыг сайжруулахад онцгой анхаарч, төлөвлөлт болон шаардлагатай төсвийг Орон нутгийн хөгжлийн сангаас хуваарилах эсвэл өөр бусад арга замаар хандивын сан байгуулж ажиллахад ач холбогдол өгч, илүү хүчин чармайлт тавин ажиллах нь зүйтэй.

#### **Сургуулийн түвшинд:**

- Сургуулийн удирдлагын баг нь сургуулийн УАЦЭА-н байгууламжийг сайжруулах, охидын өвөрмөц хэрэгцээний талаарх мэдлэг, ойлголтыг эрэгтэй багш нар, хөвгүүд, туслах ажилтнуудын (дотуур байрны ажилтан, үйлчлэгчийг оруулаад) дунд нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулах нь зүйтэй.
- Багш нар болон сурагчид нь өөрийн сургуулийн УАЦЭА-н байгууламжийн хүртээмжид гарч буй ахиц дэвшлийг хянах, мэдээлэхэд голлох үүрэгтэй оролцох хэрэгтэй. Үүнд, сургууль дээрх хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага нь туйлын чухал үүрэгтэй.
- Сургуулийн удирдлагаас сургуулийн УАЦЭА-н байгууламж, суултуур, угаалгуур, мөн шүршүүрийг ашиглаж байх үед бусдад харагдахгүй байх нууцлалын нөхцлийг ханган бүх бие засах газрын хаалгыг түгжээтэй байлгахад анхаарах нь зүйтэй.
- Сургуулиас охидод зориулж хичээлийн үеэр АЦХ амархан олж авч чадах системийг бий болгох нь зүйтэй. Үүнд, сургууль дээр жижиг мухлаг ажиллуулах, эсвэл сургуулийн эмч эсвэл охидын тусдаа өрөө зэрэг охидод аль болох хамгийн тохиромжтой байх хувилбараар, дотуур байр эсвэл ангийн багшийн санаачилгаар зохион байгуулж болно.



#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ :

1. НҮБ-ын Хүүхдийн Сан, "Сургуулийн орчинд УАЦЭА-н байдлыг хянах үнэлгээний багц" Нью-Йорк, 2011 оны 4-р сар
2. "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм,шаардлага", БСШУЯ, СЯ, ЭМСЯ, 2015, Улаанбаатар
3. "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлагын хяналт үнэлгээний багц", БСШУЯ, СЯ, ЭМСЯ, 2015, Улаанбаатар
4. "Монголын хүүхдийн байдалд хийсэн дүн шинжилгээ", НҮБХС, 2014, Улаанбаатар,
5. "Сургуулийн УАЦЭА: Кочабамбагийн хөдөө нутагт охидын боловсролыг бэхжүүлэх нь", Боливи улс, Сургуулийн орчин дахь Сарын тэмдгийн эрүүл ахуйн үнэлгээ
6. НҮБХС, "Монгол Улс дахь эрүүл ахуйн эдийн засгийн үр нөлөө", 2011
7. НҮТС (ОУБТС, 2013, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа) Монгол Улс, 2013
8. "Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт: Үндэсний дөрөв дэх илтгэлийн хураангуй", 2011.
9. "Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт: Үндэсний ахиц дэвшлийн тав дахь илтгэл", 2013.
10. <https://populationpyramid.net/mongolia/2016/>
11. "Сургуулийн УАЦЭА, Охидын боловсролыг бэхжүүлэх нь, Сургуулийн орчинд Сарын тэмдгийн эрүүл ахуйн менежментийг үнэлэх хэрэгсэл", НҮБХС, Эморийн Их Сургууль
12. <http://zasag.mn/news/view/12341>. 2016-03-02 14:54.
13. "Эрүүл мэндийг байгалийн ухаантай нэгтгэх нь шинэчлэл мөн үү?"  
2015 оны 2-р сарын 6, Зууны мэдээ.
14. "Сургуулийн УАЦЭА, Охидын боловсролыг бэхжүүлэх нь: Сургуулийн орчинд Сарын тэмдгийн эрүүл ахуйн Менежментийг хэрэгжүүлэх нь" сэдэвт виртуал их хурал, Колумбийн Их Сургууль, 2013
15. "Сургуулийн УАЦЭА, Охидын боловсролыг бэхжүүлэх нь: Сургуулийн орчинд Сарын тэмдгийн эрүүл ахуйн менежментийн үнэлгээ, Эморийн Их Сургуулийн Дэлхийн усны аюулгүй байдлын төв, НҮБХС
16. Боловсрол, шинжлэх ухааны салбарын бодлогын шинэчлэл, 1999-2014, Улаанбаатар хот, 2014
17. Талбарын удирдамж: Сургуулийн УАЦЭА-н гурван одот аргачлал, GIZ, НҮБХС, 2013
18. Модулиуд, Сургуулийн УАЦЭА ба Охид цахим курс, Эморийн Их Сургууль, 2015

## ХАВСРАЛТУУД

### ХАВСРАЛТ 1. СУДАЛГААНД ХАМРАГДСАН СУРГУУЛИУДЫН ДОТУУР БАЙРНЫ СУРАГЧДЫН ТОО

Сургуулийн код	Сургуулийн байршил ба бүс	Нийт сурагчдын тоо	Үүнээс дотуур байрны	Дотуур байрны сурагчдын %
C1	Хот	2,640	х/г	х/г
C2	Хот	2,975	х/г	х/г
C3	Хотын захын	1,426	91	6.4%
C4	Говийн бүсийн аймаг	1,057	100	9.5%
C5	Говийн бүсийн сум	1,100	84	7.6%
C6	Зүүн бүс	274	28	10.2%
C7	Зүүн бүсийн сум	584	116	19.9%
C8	Баруун бүсийн аймаг	1,059	х/г	х/г
C9	Баруун бүсийн сум	613	110	17.9%
C10	Хангай бүсийн аймаг	760	х/г	х/г
C11	Хангай бүсийн сум	512	110	21.5%

## ХАВСРАЛТ 2. СОНГОГДСОН СУРГУУЛИУДЫН ОХИДЫН БИЕ ЗАСАХ ГАЗРЫН УАЦЭА-Н СТАНДАРТ ХАНГАСАН БАЙДАЛ

Бүс	Түвшин	Ээлжийн тоо	Сурагчдын тоо, ангилал	Сурагчдын тоо	Жорлонгийн тоо	Эмэгтэй сурагчдын тоо	Охидын АЦӨ-ий суултуурын тоо *	Нэг ээлжинд нэг АЦӨ-нд ногдох охидын тоо	Стандарт хангасан (Тийм, Үгүй)
УБ	Хот	3	2,001-ээс дээш	2,640	19	1,489	6+3/2	66	Үгүй
УБ	Гэр хороолол	3	2,001-ээс дээш	2,975	24	1,524	18/2	56	Үгүй
УБ	Алслагдсан дүүрэг	2	1,001–2,000	1,426	29	726	23	16	Тийм
Говь	Аймаг	2	1,001–2,000	1,057	18	552	9	31	Үгүй
Говь	Сум	2	1,001–2,000	1,100	16	558	6	47	Үгүй
Зүүн	Аймаг	1	500 хүртэл	274	7	134	3	45	Үгүй
Зүүн	Сум	2	501–1,000	584	6	280	2	70	Үгүй
Баруун	Аймаг	2	1,001–2,000	1,059	12	525	6	44	Үгүй
Баруун	Сум	2	501–1,000	613	15	302	8	19	Тийм
Хангай	Аймаг	2	500 хүртэл	380	24	372	11	17	Тийм
Хангай	Сум	2	500 хүртэл	254	18	268	5+8/2	15	Тийм
									+охидын суудал+бүх сурагч/2

### ХАВСРАЛТ ЗА. СУРГУУЛИЙН АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨ БОЛОН УАЦЭА-Н БАЙГУУЛАМЖИД ХИЙСЭН АЖИГЛАЛТЫН ДҮН

Ажиглалт	Хариулт	УБ		Аймаг		Сум	
		Суултуурын тоо, N=79	Хувь	Суултуурын тоо, N=77	Хувь	Суултуурын тоо, N=65	Хувь
Ангилал	Ангилал						
1. Зориулалт	Охидын	32	41%	34	43%	24	37%
	Хөвгүүдийн	17	22%	35	44%	23	35%
	Нийт сурагчдын	3	4%	0	0%	12	18%
	Эмэгтэй багш нарын	1	1%	0	0%	2	3%
	Эрэгтэй багш нарын	1	1%	0	0%	2	3%
	Нийт багш нарын	5	6%	2	3%	1	2%
	Мэдэхгүй/хамааралгүй	20	25%	6	8%	1	2%
2. АЦБ-ын төрөл	Усан татуургатай	75	95%	65	81%	7	11%
	Нүхэн жорлон	4	5%	8	10%	52	80%
	Сайжруулсан, агааржуулагчтай нүхэн жорлон	0	0%	3	4%	5	8%
	Мэдэхгүй/ хамааралгүй	0	0%	1		1	2%
3. Ажиллагаатай эсэх	Ажиллагаатай	53	67%	30	38%	13	20%
	Хагас ажиллагаатай	17	22%	23	29%	22	34%
	Ажиллагаагүй	8	10%	23	29%	25	38%
	Мэдэхгүй/ хамааралгүй	1	1%	1	1%	5	8%
4. Ариун цэвэр	Цэвэр	51	65%	23	29%	13	20%
	Дунд зэргийн	16	20%	41	51%	15	23%
	Бохир	5	6%	8	10%	31	48%
	Мэдэхгүй	7	9%	5	6%	6	9%
5. Гэрэлтүүлэг	Гэрэлтэй	50	63%	56	70%	8	12%
	Тааруухан гэрэлтэй	18	23%	0	0%	2	3%
	Харанхуй	4	5%	19	24%	49	75%
	Мэдэхгүй/тодорхой бус	7	9%	2	3%	6	9%
6. Дотор түгжээ	Бий, түгжиж болно	48	61%	33	41%	12	18%
	Бий гэвч, түгжиж болохгүй	16	20%	22	28%	5	8%
	Түгжээгүй	8	10%	14	18%	42	65%
	Мэдэхгүй/тодорхойгүй	7	9%	8	10%	6	9%



Ажиглалт	Хариулт	УБ		Аймаг		Сум	
7. Гаднах цоож	Бий, түгжиж болно	74	94%	24	30%	16	25%
	Бий гэвч, түгжиж болохгүй	0	0%	18	23%	0	0%
	Огт байхгүй	0	0%	34	43%	47	72%
	Мэдэхгүй/тодорхойгүй	5	6%	1	1%	2	3%
8. Найзын туслалцаа хэрэгтэй	Хэрэгтэй	60	76%	35	44%	42	65%
	Хэрэггүй	8	10%	38	48%	21	32%
	Мэдэхгүй/тодорхойгүй	11	14%	4	5%	2	3%
9. Хогийн сав	Байгаа	73	92%	59	74%	17	26%
	Байхгүй	6	8%	18	23%	48	74%
10.Ариун цэврийн цаас	Бий	2	3%	5	6%	7	11%
	Байхгүй	77	97%	72	90%	58	89%
11. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ашиглаж болох эсэх	Болно	0	0%	1	1%	0	0%
	Боломжгүй	79	100%	76	95%	65	100%

#### ХАВСРАЛТ ЗБ. ДОТУУР БАЙРНЫ АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨНИЙ СУУЛТУУРЫН АЖИЛЛАГААНЫ БАЙДАЛ

Сургуулийн код	Бүрэн ажиллагаатай *	Хагас ажиллагаатай **	Ажиллагаагүй ***	Нийт
3.9_Хотын	7	0	0	7
4.9_Аймгийн	0	8	0	8
5.9_Сумын	0	0	4	4
6.9_Аймгийн	0	8	0	8
7.9_Сумын	1	4	1	6
Нийт	8	20	5	33
	24%	61%	15%	100%



**ХАВСРАЛТ 4 Б. АЙМГИЙН СУРГУУЛИЙН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН БОДИТ НӨХЦӨЛ БА МӨРӨӨДЛИЙН ТЭСӨӨЛЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ**

Сургуулийн байршил	Аймгийн сургууль																
	Сургуулийн код	Сургууль С4		Говийн бүс		Сургууль С6		Зүүн бүс		Сургууль С8		Баруун бүс		Сургууль С10		Хангайн бүс	
ФБЯ нас/хүйс	12–13 насны охид		14+ насны охид		12–13 насны охид		14+ насны охид		12–13 насны охид		14+ насны охид		12–13 насны охид		14+ насны охид		
Ажиллагаатай АЦБ-ын шинж чанар	Мөрөөдлийн	Одоогийн	Мөрөөдлийн	Одоогийн	Мөрөөдлийн	Одоогийн	Мөрөөдлийн	Одоогийн	Мөрөөдлийн	Одоогийн	Мөрөөдлийн	Одоогийн	Мөрөөдлийн	Одоогийн	Мөрөөдлийн	Одоогийн	
1	Хогийн сав			√	+					√	+			√		√	X
2	Дотор түгжээ	√	+			√	X	√	+	√	X	√	X			√	X
3	Хөвгүүд, охидынх тусдаа	√	X	XГ		XГ		XГ		XГ		XГ		XГ		XГ	
5	Толь	√				√	X	√	+	√	X	√	X	√	X		
6	Цэвэрхэн	√	X	√	X			√		√	X	√	X	√	X		
7	Эд юмаа тавих газар	√	X	√	X					√	X	√	X	√	X	√	X
8	Гэрэлтүүлэг													√	X	√	X
9	Өлгүүр	√	X	√	X					√	X	√	X	√	X	√	X
10	Үнэргүй	√	X							√	X	√	X	√	X	√	X
11	Агаарын солилцоотой эсвэл цонх онгойлгодог							√	+	√	X	√	X	√	X	√	X
12	Ариун цэврийн хэрэгсэл олдоцтой	√	X	√	X	√	X	√	X	√	X	√	X	√	X		
13	Хлорамины ариутгагч	√	X	√	X	√				√	X	√	X	√	+		
14	Гар угаалтуур							√	+	√	X	√	X	√	X		
15	Гар хатаагч	√	X			√	X	√	+	√	X	√	X	√	X		
16	Ариун цэврийн цаас, саван	√	X	√	X	√	X	√	X	√	X	√	X	√	X	√	X
17	Мэдээллийн самбар	√	X			√	X			√	X	√	X				
18	Татуурга нь ажиллагаатай													√	X		
19	Давхар болгонд байх	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ
20	Хангалттай зайтай													√	X		
21	Байнгын ажиллагаатай													√	X		
23	Ажиглалтын камертай CCTV							√	X								

### ХАВСРАЛТ 4В. СУМЫН СУРГУУЛИЙН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН БОДИТ НӨХЦӨЛ БА МӨРӨӨДЛИЙН ТӨСӨӨЛЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Сургуулийн байршил	Сумын сургууль																		
	Сургуулийн код	Сургууль С5		Говийн бүс		С5		Сургууль С7		Зүүн бүс		Сургууль С9		Баруун бүс		СургуульС11		Хангайн бүс	
ФБЯ нас/хүйс	12–13 насны охид		14+ насны охид		Хөвгүүд		12–13 насны охид		14+ насны охид		12–13 насны охид		14+ насны охид		12–13 насны охид		14+ насны охид		
Ажиллагаатай АЦБ-ийн шинж чанар	Мөрөөдлийн	Одоогийн	Мөрөөдлийн	Одоогийн	Мөрөөдлийн	Одоогийн	Мөрөөдлийн	Одоогийн	Мөрөөдлийн	Одоогийн	Мөрөөдлийн	Одоогийн	Мөрөөдлийн	Одоогийн	Мөрөөдлийн	Одоогийн	Мөрөөдлийн	Одоогийн	
1 Хогийн сав	√	X					√	X			√	X	√	X	√	X			
2 Дотор түгжээ	√	X	√	X	√	X	√	X	√	X	√	X	√	X	√	X			
3 Хөвгүүд, охидынх тусдаа																			
4 Дотроо дотор-логоотой /харагдахгүй	√	X	√	X							√	X			√	X	√	X	
5 Толь	√	X	√	X			√	X			√	X	√	X	√	X			
6 Цэвэрхэн	√	X	√	X	√	X	√	X	√	X	√	X	√	X					
7 Эд юмаа тавих газар			√	X							√	X	√	X					
8 Гэрэлтүүлэг	√	X	√	X			√	X			√	X	√	X	√	X			
9 Өлгүүр			√	X											√	X	√	X	
10 Үнэргүй	√	X	√	X			√	X			√	X	√	X	√	X			
11 Агаарын солилцоотой эсвэл цонх онгойлгодог	√	X	√	X			√	X	√				√	X	√	X			
12 АЦХ олдцотой			√	X	√	X	√	X	√	X			√	X	√	X	√	X	
13 Ариутгагч			√	X			√	X	√	X			√	X					
14 Гар угаах байгууламж	√	X	√	X			√	X			√	X	√	X					
15 Гар хатаагч			√	X													√	X	
16 Ариун цэврийн цаас, саван			√	X	√	X			√	X			√	X	√	X	√	X	
17 Мэдээллийн самбар											√	X	√	X	√	X			
18 Усан татуургатай	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ
19 Давхар болгонд байх	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ	XГ
20 Хангалттай зайтай байх	√	X					√	X							√	X			

#### ХАВСРАЛТ 5. ХАМРАГДСАН СУРГУУЛИУДЫН БАГШ НАРЫН ТОО, ХҮЙСЭЭР

Сургуулийн код	Бүс	Байршил	Нийт багшийн тоо	Нийт эрэгтэй багшийн тоо	Нийт эмэгтэй багшийн тоо	Эмэгтэй багш нарын эзлэх хувь
C1	Хот	Хотын төв	99	12	87	88%
C2	Хот	Хотын зах	131	14	117	89%
C3	Хот	Алслагдсан дүүрэг	74	16	58	78%
C4	Говь	Аймаг	66	15	51	77%
C5	Говь	Сум	60	12	48	80%
C6	Зүүн	Аймаг	17	4	13	76%
C7	Зүүн	Сум	31	9	22	71%
C8	Баруун	Аймаг	66	10	56	85%
C9	Баруун	Сум	34	6	28	82%
C10	Хангай	Аймаг	52	10	42	81%
C11	Хангай	Сум	33	7	26	79%

## ХАВСРАЛТ 6. ОРОЛЦОГЧДООС ГАРСАН ЗӨВЛӨМЖҮҮДИЙН НЭГТГЭЛ

Тодорхойлогч хүчин зүйлс	Сургууль, сургуулийн захиргаанд хандсан зөвлөмжүүд	12–13 насны охид	14+ насны охид	14+ насны хөвгүүд	Багш нар	Эж нар	Сургуулийн удирдлага
Сургуулийн УАЦЭА-н байгууламжийг сайжруулах	<ul style="list-style-type: none"> <li><input type="checkbox"/> Охид ба хөвгүүдэд тусдаа ариун цэврийн өрөөний тоог хангалттай болгож, засварлах</li> <li><input type="checkbox"/> Охидын ариун цэврийн өрөө нь хувийн нууцлалыг хангасан байхад анхаарах</li> <li><input type="checkbox"/> Ариун цэврийн өрөө бүр дотроо түгжээтэй, гэрэлтүүлэг сайтай, тольтой, гар хатаагчтай, саван, 00-ийн цаастай байх</li> <li><input type="checkbox"/> Ариун цэврийн өрөө бүр хогийн савтай байх</li> <li><input type="checkbox"/> Угаалтуур нь жорлонтой ойрхон байх, сурагчид бие зассан даруй гараа угаах боломжтой байх</li> <li><input type="checkbox"/> Ариун цэврийн өрөөний дотор АЦХ бүхий шүүгээ байх</li> <li><input type="checkbox"/> Сургууль, дотуур байранд охид хэрэгтэй үедээ хувцсаа сольж, угааж байх тусдаа өрөөтэй байх</li> <li><input type="checkbox"/> Ариун цэврийн өрөөг байнга цэвэрхэн байлгах</li> <li><input type="checkbox"/> Сургуулийн ариун цэврийн өрөөг цаг тухайд нь засварлаж байх</li> <li><input type="checkbox"/> Сарын тэмдгийн эрүүл ахуй, УАЦЭА-н байгууламжид хяналт тавих сурагчдын өөрийн удирдлагын байгууллагуудаас санаачилсан кампанит ажил, сургуулийн хэмжээнд явуулж буй ажлыг сургуулийн удирдлагаас бүрэн дүүрэн дэмжиж, урамшуулж байх</li> </ul>	C4C1, C4, C5, C9, C7, C11, C10	C9, C1, C2, C3, C4, C10	C11, C5	C9, C7		
Нийгэм- сэтгэл зүйн дэмжлэгт орчин бүрдүүлэх	Сургуулийн багш нар, ялангуяа эрэгтэй, болон хөвгүүдэд ойлголт бий болгох сургалтаар дамжуулан охидын өвөрмөц хэрэгцээг ойлгон, тэднийг дэмжих байдлыг сайжруулах, улмаар эрэгтэй багш нараас хөвгүүдэд үлгэр дууриал үзүүлж, хөвгүүдийн зүгээс охидод дээрэнгүй хандахыг нь зогсоох	C9	C11		C10		
	Охидыг ариун цэврийн өрөө ашиглахыг хүссэн үед нь багш нар зөвшөөрч байх						
	Сургуулийн төсөвтөө АЦХ-ийн үнийг тусгах нь зүйтэй. Боловсролын салбарын төсөв нь төсвийн төрлөөр хуваарилагддаг. Хэрвээ шатахууны зардлаас зарим мөнгө нь хэмнэгдсэн бол буцааж хураагддаг. Үүний оронд уг мөнгийг УАЦЭА-н байгууламжийг сайжруулахад зарцуулах нь зүйтэй.						
						C9	

Бүх нийтийн мэдлэг, мэдээлэл ба боловсролыг бэхжүүлэх	Эрүүл мэндийн хичээлийг сургалтын хөтөлбөрт дахин үргэлжлүүлэн оруулж, хөвгүүд ба охидод тусад нь заах. Сурагчдад сарын тэмдгийн эрүүл ахуйн талаар шинжлэх ухааны үндэстэй мэдлэг олгох.	C9, C2		C3, C4	C4	C2	
	Охидод зориулсан гарын авлага эсвэл товхимол нь хэтэрхий онолын бус бодит түүх эсвэл туршлага дээр суурилсан уншихад энгийн, практик хэрэглээ сайтай байх нь зүйтэй. МСС-ны материал нь мөчлөгөө хэрхэн тэмдэглэх, биеийн юм ирсэн үеэр хэвлийгээр өвдсөн үед ямар арга хэмжээ авах, өвдөлт ихтэй үед эм уух нь зүйтэй юу, яагаад хоёр эсвэл гурван сар ирэхгүй байснаа үргэлжлүүлэн ирэх, үүнийг зогсоож болох боломжтой талаар тусгасан байх. Түүнчлэн охидод зориулсан тараах материал нь ариун цэврийн хэрэгслийн тухай, хэрхэн хэрэглэх, хэр ойрхон солих, өөртөө хэрхэн анхаарал тавих г.м. талаар байх нь зүйтэй.	C11, S5 C10	C9, C10, C7, C11,	C6,			
	Тараах материалыг товхимол хэлбэрээр бэлтгэж болно. Зөвлөмжүүдийг интернэтээр, харин товхимлыг сургуулийн сурагчид, охид ба хөвгүүдэд тараахаар шийдэж болох юм.	C4, C10,		C6			
	Сургуулиуд нь сар бүр эсвэл долоо хоногт эсвэл шуудангийн хайрцагаар биеийн юмны талаар мэдээлэл тараан сурагчид асуулт асуух боломжтой байх нөхцлийг хангах ажлыг хариуцан явуулах нь зүйтэй. Ганцаарчилсан уулзалтын өрөө байх хэрэгтэй.	C10	C6		C6	C8	
	Үе тэнгийн сургагчдаар дамжуулан охидод мэдлэг олгож болно. Охидын хувьд багш, сургуулийн эмчээс илүүтэй сургуулийн манлайлагч охидын үгийг сонсож, хүлээн зөвшөөрдөг.		C7		C10		
	Хүүхдүүд видео үзэх дуртай тул кино, видеог ашиглан ойлголт сайжруулж болох талтай.		C10				
	Үйлчлэгч нарт охидын хэрэгцээг ойлгуулж, харилцааны ур чадварын сургалт явуулах хэрэгтэй.	C4, S10, C5, C11,	C10				
	Хөвгүүдэд охидын хэрэгцээний талаар мэдлэг олгож, тэднийг шоолохгүй байхад сургах нь зүйтэй.	C4, S10, S5, C11	C6, C11, C9,				
	Эцэг эхчүүд охидтойгоо нээлттэй ярилцах, тэдэнд АЦХ авах мөнгө байнга өгч байх, мөн аав нар охиддоо анхаарал тавьдаг байх хэрэгтэй.	C2, C4, S7	C2, C3, C8, C6, C9		C10	C2	
	Эцэг эхчүүд өөрийн охиндоо анхаарал тавих, ялангуяа хувийн эрүүл ахуйгаа сахих тал дээр, бас хүнд юм өргүүлэхгүй байхад анхаарах		C2				
	Эцэг эхчүүд сургалтанд хамрагдах ёстой бөгөөд тэднийг товхимол, гарын авлагаар хангах нь зүйтэй.	C5, C7	C9				

Яаралтай үед хэрэглэх материалын хүртээмжийг сайжруулах	АЦХ-ийг заарах цэгтэй болох эсвэл сургуулийн бусад дотоод нөөц бололцоог ашиглан тодорхой систем бүрдүүлэх зэргээр АЦХ-ийн хүртээмжийг сайжруулах .	C5, C9, C7	C6, C10		C6	C3, C9	
	Эмэгтэй багш нар эсвэл сургуулийн эмч нар окидоос мөнгө цуглуулж яаралтай үед хэрэглэх АЦХ-ийн нөөц бий болгох эсвэл окидод хэрэгцээ гарсан үед хэрэглэх хэрэгслийг хадгалж байх. АЦХ зардлыг сургуулийн төсөвт суулган, яаралтай үеийн хэрэгцээг хангах боломж бүрдүүлэх.	C2, C9	C4, C5				
Биологийн хүчин зүйлс	Сургуулийн эмч, багш нар, дотуур байрны багш нараас сарын тэмдгийн үед хэрхэн биедээ анхаарал тавих, хийж болох ба болохгүй зүйлс, ямар хэрэгсэл хэрэглэх, өвдөлт зэрэг биед таагүй мэдрэмжээс хэрхэн салах талаар цагаа олсон, холбоотой, хэрэг болох зөвлөмжийг окидод өгч байх.	C3, C7					
	Охидын эрүүл мэндийн үзлэгийг жилдээ нэг удаа зохион байгуулах нь зүйтэй.		C5, C3				





